

(ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМАНД БАЙРЛАХ “ИХ ТҮМЭН ХҮРД” ХХК-ИЙН
АЛАГ ЦАВ НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙ)

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

(MV021559, РД:6375839)

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН...../

/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ИХ ТҮМЭН ХҮРД ХХК-ИЙН ЗАХИРАЛ...../ Ж.ДАШХОРОЛ/

ИХ ТҮМЭН ХҮРД ХХК-ИЙН УУРХАЙН ДАРГА /С.АЛТАНГЭРЭЛ/

ИХ ТҮМЭН ХҮРД ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН /Х.БАТТӨГС/

2024 он

Гарчиг

1.	ИХ ТҮМЭН ХҮРД ХХК-ИЙН АЛАГ ЦАВ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	8
1.1.	Түмэн айл чулуун нүүрсний ордын талбайн газар зүйн байршил	8
1.2.	Уулын хэсэг.....	9
1.3.	Ил уурхайн ерөнхий үзүүлэлтүүд:.....	9
1.4.	Уурхайн төлөвлөлтийн ерөнхий шийдлүүд:.....	10
1.5.	Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал.....	10
1.6.	“Их Түмэн Хүрд” ХХК-ийн Алаг цав төслийн ажилчдын амрах хотхон	12
2.	ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1.	Газрын гадарга, уул зүй:	12
2.2.	Уур амьсгал:	13
2.3.	Усан сүлжээ:.....	13
2.4.	Ургамал:	13
2.5.	Ан амьтан:	13
2.6.	Гидроеологи	14
2.7.	Дэд бүтэц, эдийн засаг, хүн ам:	14
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
3.1.	Газрын гадаргад үзүүлэх гол нөлөөлөл.....	16
3.2.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	16
3.3.	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
3.4.	Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	17
3.5.	Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	17
3.6.	Усан орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл.....	17
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	17
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
5.1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ	18
5.2.	Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт	24
	Ус ашиглалт.	24
5.3.	Усны зохистой ашиглалтын талаар мэдлэг олгох сургалт:	25
5.4.	Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр	27
5.5.	Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт.....	28
5.6.	Ургамалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт	32
5.7.	Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн арга хэмжээний биелэлт	33
6.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	36

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
7.1. Төлөвлөгөөний хэрэгжилт:	40
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	43
9. ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	44
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	44
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	50
11.1 Хог хаягдлын бүртгэл, тоо хэмжээ	56
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	61
12.1. АЛАГ ЦАВ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН	65
12.1.1. Алаг Цав төслийн мониторингийн цэг, байршил	66
12.2. АГААРЫН ЧАНАР	67
Уурхай орчмын агаарын чанар	67
12.3. Усны хяналт шинжилгээ	71
12.3.1. Судалгааны аргазүй	71
12.3.2. Судалгааны үр дүн:	71
Дүгнэлт:	75
12.4. ХӨРСӨН БҮРХЭВЧ	75
12.4.1. Судалгааны аргазүй	75
12.4.2. Хөрсний хяналт шинжилгээ, мониторинг	76
12.4.3. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт, морфологи бичиглэл	76
12.4.4. Хөрсний хими, физик шинж чанар	79
12.4.5. Хөрсний хүнд металлын бохирдол	81
12.4.6. Дүгнэлт:	82
12.5.1. Судалгааны ерөнхий тойм	82
12.5.2. Ургамалжлын ерөнхий төлөв	82
12.5.3. Судалгааны аргазүй	83
12.5.4. Судалгааны үр дүн	83
12.5.5. Уурхайн талбай орчмын ургамлын бичиглэл.	86
12.5.6. Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	93
12.6. АЛАГ ЦАВ ТӨСЛИЙН 2024 ОНЫ АМЬТНЫ АЙМГИЙН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН	94
12.6.1. Судлагдсан байдал	95
12.6.2. Судалгааны ажил	96

12.6.2.1.	Судалгаа явуулсан маршрут.....	96
12.6.3.	Хоёр нутагтан, мөлхөгчид	98
12.6.4.	Шувууд	100
12.6.5.	Хөхтөн амьтад.....	102
12.6.7.	Зарим амьтдыг мөрөөр тодорхойсон байдал	112
12.6.8.	Уурхайн орчны хяналт шинжилгээ хийхэд анхаарах, цаашид ан амьтны чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын зөвлөмж, дүгнэлт	114
13.	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .	115
13.1.	Хэрэгжилт.....	115
13.1.	Байгаль орчны менежментийн батлагдсан дотоод журмууд	116
14.	НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	118
15.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал.....	119

ЗУРГУУДЫН ЖАГСААЛТ

Зураг№ 1.	Ордын байршлын зураг	8
Зураг№ 2.	Алаг Цав уурхай	10
Зураг№ 3.	Уурхайн техникүүд	11
Зураг№ 4.	Нүүрсний талбай	11
Зураг№ 5.	Уурхайн амрах хотхон	12
Зураг№ 6.	Уурхайн технологийн замууд	18
Зураг№ 7.	Уурхайн технологийн замын хурдны хязгаарлалтын тэмдэг	19
Зураг№ 8.	Уурхайн нүүрс тээврийн зам.....	19
Зураг№ 9.	Уурхайн нүүрсний агуулахаас нүүрс салхинд хийсэхээс хамгаалж 2 талаар нь овоолго үүсгэсэн байдал	20
Зураг№ 10.	Тоосжилтыг бууруулах 1 км замын туршилтын ажил.....	21
Зураг№ 11.	Орон нутгийн зам засварын ажил.....	21
Зураг№ 12.	Малчны худаг, унд ахуйн худгийн байр, тоолууржуулсан байдал	25
Зураг№ 13.	Уурхайн ажилчдад БО-ны сургалт орж байгаа нь	25
Зураг№ 14.	Ил уурхайн уурхайн ухаш (карьер)	27
Зураг№15.	Шимт хөрс хуулалт, хадгалалт	28
Зураг№ 16.	Газар хөндөх зөвшөөрлийн маягт.....	28
Зураг№ 17.	Газар хөндөх зөвшөөрөл олгосон бүртгэл	29
Зураг№ 18.	Засварын газар, ШТС, Шатах тослох материалын агуулах хөрс бохирдохоос сэргийлж цементэн хучилттай болгосон байдал	29
Зураг№ 19.	ШТС, Засварын газарт байрлуулсан асгаралтын иж бүрдэл, асгаралтын журам мөрдөн ажилладаг.....	30
Зураг№ 20.	Төслийн талбайн ургамлын мониторингийн судалгаа	32
Зураг№ 21.	Төслийн талбайд байрлах Хулангийн сүрэг уст цэгээс тогтмол ус уудаг	34
Зураг№ 22.	Төслийн талбай орчимд Хулангийн 4-5 сүрэг тархан байршдаг	34
Зураг№ 23.	Арван Наймын богд уулын орчимд Аргалын сүрэг.....	35

Зураг№ 24. Нүүрсний агуулах шимт хөрс хуулалт	37
Зураг№ 25. Уурхайн технологийн замын шимт хөрс хуулалт	37
Зураг№ 26. Хаягдал хөрсний овоолго дээр биологийн нөхөн сэргээлт хийсэн туршилтын талбай	38
Зураг№ 27. Хаягдлын овоолго дээрх туршилтын талбайд шимт хөрсийг бордоотой хольж дэвсэлт хийж байгаа нь	38
Зураг№ 28. Мод тарьсан талбай	39
Зураг№ 29. Модны усалгаа арчлалтыг тогтмол хийж байна	39
Зураг№ 30. Тарьсан модны ургалтын байдал	39
Зураг№ 31. Ан амьтдад зориулсан хөв цөөрөм байршил (Уст цэг уурхайгаас 1.5 км-д)	41
Зураг№ 32. Мал ан амьтад зориулсан хөв цөөрөм (хиймэл нуур)	41
Зураг№33. Мандах сумын нутаг Боомт гэх газарт эвдэрсэн талбайг нөхөн сэргээж суманд хүлээлгэн өгсөн	42
Зураг№34. 2-р багийн нутагт дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээх талбай	42
Зураг№ 35. Нөхөн сэргээлт хийгдсэний дараа	42
Зураг№36. Орон нутагт хүлээлгэн өгсөн ковш	43
Зураг№ 37. Галын сарай, галын хорыг уурхайн обьектуудад байрлуулсан байдал	45
Зураг№ 38. Галын хор шалгасан үзлэгийн хуудас	46
Зураг№ 39. ХАБЭА-н мэдээллийн самбар	46
Зураг№40. Алаг Цав төслийн кемп, Засварын газарт, ШТС-т галын самбар, сарай байрлуулсан	46
Зураг№ 41. Төмөр замын гарам дээр хаалт хийж машин техникийн аюулгүй байдлыг хангасан байдал	47
Зураг№ 42. ХАБЭА-н сургалтууд, БО-ны сургалт, ХАЛМ-ын сургалт	47
Зураг№ 43. 2024.06-р сард сумын хогийн цэгийг техникээр ландфилдэн булшилж байгаа нь	51
Зураг№44. “Алаг Цав” төслийн ажилчдын хотхоны хог хаягдал ангилан ялгах цэг	51
Зураг№45. Хуванцар сав ангилан ялгалт	51
Зураг№ 46. Ашигласан хаягдал тосыг шилжүүлэн өгч байгаа нь	52
Зураг№47. Тээврийн зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээ	53
Зураг№48. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн цэг	66
Зураг№49. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж буй байдал	68
Зураг№ 50. Хөрсний судалгааны цэг-1, Ажилчдын хотхон	76
Зураг№ 51. Хөрсний судалгааны цэг-2, Хатуу хог хаягдлын цэг	77
Зураг№ 52. Хөрсний судалгааны цэг-3, Засварын газар	77
Зураг№ 53. Хөрсний судалгааны цэг-4, Шатахуун түгээх станц	78
Зураг№ 54. Хөрсний судалгааны цэг-5, Уурхайн машин паркын талбай	78
Зураг№ 55. Ургамлын бичиглэл №1 шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана - таанат цөлөрхөг хээрийн бүлгэмдэл	88
Зураг№ 56. Ургамлын бичиглэл №2 шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст хээрийн бүлгэмдэл	90
. Зураг№ 57. Ургамлын бичиглэл №3 шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст хээрийн бүлгэмдэл	92
Зураг№ 58. Ургамлын бичиглэл №4 ногоон хоног будаа, үслиг манан хамхагын синуз үүсгэсэн талбай	93
Зураг№ 59. Ургамлын зурагт альбом	94
Зураг№ 60. Монгол орны хөхтөн амьтдын тархацын зураг	95

Зураг№ 61.Судалгааны явцад ажиглагдсан амьтадын байршил.....	97
Зураг№ 62. Арван наймгийн Богд уул (Орон нутгийн тусгай хамгаалалттай газар)	98
Зураг№ 63. Уурхайн баруун урд талын хөндий	98
Зураг№ 64. Уст цэг №1 эрэг орчимд байсан Хар хэрээ(Corvus)-ний мөр	101
Зураг№ 65. Уурхайн камп-д Хадны тагтаа(Columba rupestris)	101
Зураг№ 66. Монгол хулан жороо (Podoces hendersoni) (N44°10'137"; E108°10'014").....	102
Зураг№ 67. Хулан адуу 7 толгой уурхайгаас баруун зүгт, байршил (N44°08'55.5"; E108°14'13.0").....	106
Зураг№ 68. Уст цэг №2. Хулан адуу 4 толгой , 12 цагт усанд орж буй байршил.....	107
Зураг№ 69. Уст цэг №1-ийн ойролцоо. Хулан адуу 22 толгой , 18:20 цагт усанд орж буй байршил(N44°08'55.5"; E108°14'13.0")	107
Зураг№ 70. Аргаль хонь 10 толгой уурхайгаас баруун урд зүгт, байршил	109
Зураг№ 71. Арваннаймын Богд уулын зүүн хойно Аргаль хонины 7 бодгалийн байршил	109
Зураг№ 72. Хар сүүл 7 толгой, уурхайгаас баруун хойд зүгт, байршил (N44°05'192";E108°13'343").....	111
Зураг№ 73 Хулангийн мөр.	Зураг№ 74. Хар сүүлтийн мөр.
Уст цэг№1.	113
Зураг№ 75. Уст цэг №1 орчмын зэрлэг амьтны мөр (N44°09.050'; E108°14.233').....	113
Зураг№ 76. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” -ийн хаврын аяны хүрээнд сумын шилдэг 5 сурагч мод тарилцсан	116
Зураг№ 77. Шилдэг эссэ бичлэгээр шалгарсан сурагчдад шагнал гардуулах арга хэмжээ	117
Зураг№ 78. Сурагчдын уурхайтай танилцах аялал, байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлын танилцуулга	118

ГРАФИКУУДЫН ЖАГСААЛТ

График№ 1. Нийт усны зарцуулалт	24
График№ 2. Хүхэрлэг хийн үзүүлэлт	69
График№ 3. Азотын давхар ислийн үзүүлэлт.....	69
График№ 4. Нийт тоосны үзүүлэлт	69
График№ 5. Дуу чимээ.....	70
График№ 6. Гол ионуудын агууламж (Стифф)	72
График№ 7. Уурхайн орчмын ургамлын овгуудын эзлэх хэмжээ (А- 2023 он В- 2024 он) ..	86
График№ 8.2023-2024 оны ан амьтны харьцуулсан судалгаа.....	103

ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт№ 1. Лицензийн талбайн солбицол.....	8
Хүснэгт№ 2. Уурхайн ерөнхий үзүүлэлт	9
Хүснэгт№ 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	15
Хүснэгт№ 4. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	22
Хүснэгт№ 5. Уурхайн ус ашиглалт.....	24
Хүснэгт№ 6. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	26
Хүснэгт№ 7. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт	31
Хүснэгт№ 8.Нүүрсний агуулах урд талд хийгдсэн ургамлын бичиглэл (1 м ² -ийн ургамал)	32

Хүснэгт№ 9.Ургамлан нөмрөг үзүүлэх сөрөг нөлөөллийг буурулах төлөвлөгөөний биелэлт	33
Хүснэгт№ 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	36
Хүснэгт№ 11. Шимт хөрсний хуулалт, хэлбэршүүлэлт	37
Хүснэгт№12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	40
Хүснэгт№ 13. 4-р багийн иргэдэд хүлээлгэн өгсөн нүүрс.....	43
Хүснэгт№14. Түүх, соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	44
Хүснэгт№15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	48
Хүснэгт№16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	54
Хүснэгт№17. Хог хаягдлын мэдээ, тайлан	56
Хүснэгт№18. Алаг Цав төслийн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлын бүртгэл.....	57
Хүснэгт№19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	62
Хүснэгт№ 20 Дээж авсан цэгийн байршил	66
Хүснэгт№21. Агаарын хэмжилт хийсэн газрын координат цэг.....	68
Хүснэгт№22. Агаарын чанарын шинжилгээний үр дүн	68
Хүснэгт№ 23. Гүний худгуудын байршил	71
Хүснэгт№ 24. Шинжилгээний нэгдсэн дүн (ундны ус)	73
Хүснэгт№ 25. Хөрсний мониторингийн координат цэг	76
Хүснэгт№ 26. Хөрсний хими физик шинж чанар, 2024 оны 5 дугаар сар.....	79
Хүснэгт№ 27.Хөрсний механик бүрэлдэхүүн, 2024 оны 5 дугаар сар.....	80
Хүснэгт№ 28. Шимт хөрсний.....	80
Хүснэгт№ 29. Хөрсний хүнд металлын бохирдлын үндсэн үзүүлэлтүүд.....	81
Хүснэгт№ 30. Ургамлын арви, тусгагийн бүрхэц, тааралдаа хоорондын харьцаа	83
Хүснэгт№ 31. Алаг цав” нүүрсний уурхай орчмын талбай дахь ургамлын зүйлийн бүрдэл	84
Хүснэгт№ 32. Бичиглэл №1 (1 м ² -ийн ургамал).....	87
Хүснэгт№ 33. Бичиглэл №1 орчмын ургамлын зүйлийн бүрдэл.....	87
Хүснэгт№ 34. Бичиглэл №2 (1 м ² -ийн ургамал).....	89
Хүснэгт№ 35. Бичиглэл №2 орчмын ургамлын зүйлийн бүрдэл.....	89
Хүснэгт№ 36. Бичиглэл №3 (1 м ² -ийн ургамал).....	91
Хүснэгт№ 37. Бичиглэл №3 орчмын ургамлын зүйлийн бүрдэл.....	91
Хүснэгт№ 38. Бичиглэл №4 (1 м ² -ийн ургамал).....	92
Хүснэгт№ 39.Бичиглэл №4 орчмын ургамлын зүйлийн бүрдэл.....	92
Хүснэгт№ 40. Судалгааны байршлын хүснэгт	96
Хүснэгт№ 41. Монгол хулан жороо (Podoces hendersoni).....	101
Хүснэгт№ 42. Бүс нутгийн хэмжээнд ховордож байгаа (Устаж байгаа, устаж болзошгүй, эмзэг) болон ховордож болзогүй хөхтөн амьтад.....	103
Хүснэгт№ 43. Хулан адуу (equus hemionus)	105
Хүснэгт№ 44. “Алаг цав” уурхайн орчимд тохиолдсон Хулан адуу (Equus hemionus)-ны байршил, бодгалийн тоо	106
Хүснэгт№ 45. Аргаль хонь- ovis ammon (linnaeus, 1758)	108
Хүснэгт№ 46. Хар сүүлтий-gazella subgutturosa (guldenstadt, 1780).....	110
Хүснэгт№ 47. “Алаг цав” уурхайн орчимд тохиолдсон Хар сүүлтий(Gazella subgutturosa)-ны байршил, бодгалийн тоо	111
Хүснэгт№ 48. Уст цэг орчмын зарим хөхтөн амьтдыг мөрөөр тодорхойлсон байдал	112
Хүснэгт№ 49. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт	115

Хүснэгт№ 50. Байгаль орчны менежментийн батлагдсан дотоо журмууд.....	116
Хүснэгт№ 51. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	118
Хүснэгт№ 52. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжүүлсэн зардал	119


ХАВСРАЛТУУДЫН ЖАГСААЛТ

Хавсралт№ 1. Алаг Цав төслийн усны шинжилгээ	120
№ 2. Алаг Цав төслийн хөрсний шинжилгээний дүн	131
Хавсралт№ 3. Алаг Цав төслийн агаарын шинжилгээний дүн	137
Хавсралт№ 4. Кадастрын лавлагаа	139
№ 5. Уулын ажлын төлөвлөгөөний нүүр	141
Хавсралт№ 6. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө төлсөн баримт.....	142
Хавсралт№ 7 Хог хаягдлын төлбөр төлсөн баримт	143
Хавсралт№ 8 Аюултай хог хаягдал тушаасан төлбөрийн баримт.....	145
Хавсралт№ 9 Хаягдал тос нийлүүлэх гэрээ	148
Хавсралт№ 10 Хаягдал тос нийлүүлсэн баримт	149
Хавсралт№ 11 2023.2024 оны мод тарьсан талбайн байршлын зураг.....	150
Хавсралт№ 12. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийсэн талбай	151
Хавсралт№ 13. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	152
Хавсралт№ 14. Ус ашиглах гэрээ.....	153
Хавсралт№ 15. Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх гэрээ.....	157
Хавсралт№ 16. Байгаль орчны аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ.....	159

1. ИХ ТҮМЭН ХҮРД ХХК-ИЙН АЛАГ ЦАВ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Түмэн айл чулуун нүүрсний ордын талбайн газар зүйн байршил

Түмэн айлын чулуун нүүрсний орд нь Дорноговь аймгийн Мандах сумын төвөөс урагш 30 км, Сайншанд хотоос баруун урагш 200 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 484 км, БНМАУ-БНХАУ хилийн Ханги-Мандал боомтоос баруун хойш 235 км-т байрлана.



Зураг № 1. Ордын байршлын зураг

Хүснэгт № 1. Лицензийн талбайн солбицол

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбицол нь: L-49-133					
MV-021559 (932.13 га)	2020-04-01	30	1	108°16'50.13"	44°07'51.05"
			2	108°16'50.13"	44°09'20.35"
			3	108°14'18.03"	44°09'20.35"
			4	108°14'18.03"	44°07'51.05"

1.2. Уулын хэсэг

Түмэн айлын чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ашиглах ил уурхайн хажуугийн тогтворжилтын тооцоог чулуулгийн физик механик шинж чанарт тулгуурлан Г.Л.Фисенкогийн аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн.

Чулуулгийн физик механикийн шинж чанарын үзүүлэлтүүдийг ШУТИС-н харьяа Уул уурхайн хүрээлэнгийн чулуулгийн лабораторид 2012 онд ордын агуулагч чулуулагт хийлгэсэн тайлангийн үр дүнг үндэслэн сонгосон. Ордыг 860 м-ийн түвшин хүртэл ашиглах ба газрын гадаргаас доош 190 м гүн ухаш үүснэ.

Нүүрсний давхаргын зузаан нь дунджаар 5-7 м.

Түмэн айлын чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил уурхайн хажуугийн тогтворжилтын тооцоог чулуулгийн физик механик шинж чанарт тулгуурлан тогтворжилтын аргуудын нэг болох төгсгөлөг элементийн арга ашиглан “Phase 2” программ хангамж дээр хийж гүйцэтгэсэн.

Уг үнэлгээний ажил нь геологи, структур, геотехникийн зураглал, өрөмдлөг, чулуулгийн физик механикийн шинж чанар тодорхойлох лабораторийн тест, зардлын хувьд хэмнэлттэй, үйлдвэрлэлд тавигддаг аюулгүй ажиллагааны дүрэм журмуудыг хангасан уурхайн хажуугийн өнцгүүдийг тодорхойлох тогтворжилтын шинжилгээ зэргээс бүрдэнэ.

Хүснэгт № 2. Уурхайн ерөнхий үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Доголын өндөр	м	5
2	Доголын хажуугийн өнцөг	град	50
3	Аюулгүйн тавцангийн өргөн	м	5-7
4	Уурхайн замын өргөн	м	30-45
5	Уурхайн ерөнхий хажуугийн өнцөг	град	28-34

1.3. Ил уурхайн ерөнхий үзүүлэлтүүд:

Ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанарыг үндэслэн уурхайн ерөнхий налуугийн өнцгийг 28-35 градусаар тогтоосон,

- Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмжүүдийн параметрийг үндэслэн хөрс хуулалт нүүрс ашиглалтын үеийн доголын өндрийг 5 м-ээр тогтоосон,
- Ажлын талбайн өргөн 30 м,
- Мөргөцөгт ажиллах экскаваторын орлын өргөн дунджаар 20 м,
- Доголын налуугийн өнцөг нь 55 градус,
- Замын өргөн 30 м тус тус байна.

1.4. Уурхайн төлөвлөлтийн ерөнхий шийдлүүд:

Хөрсний овоолгыг эдийн засгийн хувьд ашиглах боломжтой нөөцөөс гадна уурхайн эцсийн гүндээ хүрэх үеийн хүрээ хязгаараас гадна байрлуулсан. Түмэн айлын чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ашиглах ил уурхайгаас гравитацийн аргаар баяжуулах үйлдвэрт түүхий эдээ нийлүүлнэ. Уурхайгаас гарсан нүүрсийг БНХАУ-н зах зээлд нийлүүлнэ.



Зураг № 2. Алаг Цав уурхай

1.5. Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдаж авахаар энэхүү төсөлд тусгалаа. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 170 мм-ийн диаметртай цооног өрөмдөх чадалтай CM458 маркийн өрмийн машин
- 5 м³-ийн утгуурын багтаамжтай XCMG 700 маркын урвуу утгуурт ачигч-6ш
- 3 м³-ийн утгуурын багтаамжтай XCMG-490 маркийн урвуу утгуурт экскаватор
- 90 тонны даацтай -XDM80 м маркийн автосамосвал-18ш
- Dongfeng маркийн зам усалгааны машин-2ш
- 3.0 м³ –н шанаганы багтаамжтай “XCMG-50” маркийн утгуурт ачигч-3ш
- 114 кВт хүчин чадалтай DT-140B маркийн бульдозер
- Грейдер бусад туслах машин, механизм



Зураг № 3. Уурхайн техникүүд



Зураг № 4. Нүүрсний талбай

1.6. “Их Түмэн Хүрд” ХХК-ийн Алаг цав төслийн ажилчдын амрах хотхон

- 250 хүн хүлээн авах хүчин чадалтай
- Халаалт, цэвэр бохир усанд холбогдсон
- Ажилчдын амрах, чөлөөт цагаа өнгөрөөхөд зориулагдсан сагс, волейболын талбай
- Зочид төлөөлөгчдийг хүлээн авах гэр, хотхон байна.
- Зоогийн газар
- Угаалгын газар
- Уурын зуух



Зураг № 5. Уурхайн амрах хотхон

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Газрын гадарга, уул зүй:

Түмэн айлын чулуун нүүрсний орд нь говийн тэгш тал, нам толгодорхог төрхтэй, газрын гадаргын үнэмлэхүй өндөршил 1042.9-1085.4 м, үйлдвэрийн ач холбогдолтой нүүрсний давхраас тархсан 540 га талбайн хэмжээнд тэгш тал, нам гүвээ, толгодорхог гадарга зонхилох бөгөөд тэдгээрийн харьцангуй өндөр 40 м-ээс хэтэрдэггүй.

Өргөргийн дагуу сунаж тогтсон хадархаг гадаргатай хяр, толгод, бүлэг уулсаас бүрдсэн өндөрлөг уулсын бүс болох “Арван наймын Богд уул” орд газраас хойш 10-12 км зайд орших бөгөөд 1238-1398 м үнэмлэхүй өндөр, 100-200 метрийн харьцангуй өндөртэй байгаа нь ордоос 80 хүртэл

км тойрогт байх газрын гадаргын хамгийн өргөгдсөн хэсэг болж байгаа юм. “Арван наймын Богд уул”-н бүсийг 2012 оны 05 сарын 30-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 191-р тогтоолоор байгалийн нөөц газарт авсан байдаг.

2.2. Уур амьсгал:

Талбай нь бүхэлдээ говийн бүсэд хамаардаг ба эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд (6-8 сард) $+42^{\circ}\text{C}$ хүртэл (дунджаар $+23^{\circ}$) халж, өвлийн улирал (1-2 сард) -40°C хүртэл (дунджаар -13°) хүйтэрдэг. Жилийн дундаж температур $+6^{\circ}$ байна. Баруун хойд, хойд болон зүүн хойд чиглэлийн салхи зонхилох ба салхины жилийн дундаж хурд 4-12 м/сек, 3-р сараас 6-р сар хүртэл салхи шуурга их үргэлжилдэг бөгөөд зарим үед салхины хүч 20-35 м/сек ширүүсдэг. Жилд унах хур тунадас дунджаар 100-200 мм, хамгийн их унах үе 7, 8 сар байдаг.

Өвлийн улиралд цас бага ордог. Олон жилийн ажиглалтаар 11 сарын сүүлч 12 сарын эхэн үеэс зарим жилүүдэд цасан бүрхүүл тогтож 3 сарыг дуустал үргэлжилнэ. Цасан бүрхүүлийн зузаан дунджаар 10-20 мм, зарим зудтай жилд 250 мм хүрэх нь бий.

2.3. Усан сүлжээ:

Талбайн хэмжээнд гадаргуугийн усны тархалт маш дутмаг, гол горхи байхгүй, хур тунадсаар тэжээгддэг нуур тойрмууд зөвхөн хуртай жилүүдэд бий болдог. Иймд нутгийн иргэд, малчид гар болон гүний худгуудыг ашиглан аж ахуйн болон ундны усны хэрэгцээгээ хангадаг.

Түмэн айлын чулуун нүүрсний ордын хилээс хамгийн ойр зайд байрлах Хошуу хондны өрөмдмөл худаг ордын хойд захаас 200 метрт байдаг бол Шаварт, Баян шанд, Хар толгой зэрэг гар худгууд ордын төвөөс 5.4-5.8 км-т байрладаг.

2.4. Ургамал:

Ордын хэмжээнд говийн сийрэг ургамлын бүрхэвчтэй. Говийн бүсэд ургадаг хялгана, таана, хөмүүл, бор бударгана зэрэг өвслөг ургамал ургамлын бүрхэвчийн зонхилох хэсгийг бүрдүүлж байна. Хотир, сондуул, харгана зэрэг бутлаг ургамал гуу жалга хуурай сайрын дагуу сийрэгхэн тархацтай ургасан байдаг.

2.5. Ан амьтан:

Ордын хэмжээнд говь цөлд хаа сайгүй тааралддаг жигүүртэн болон мэрэгч амьтад байхаас гадна хулан, хар сүүлт, аргаль, янгир зэрэг ховордсон амьтад хааяа тааралддаг. Ордоос Түмэн айлын чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл “Их түмэн хүрд” ХХК MV-021559 хойш байрлах “Арван наймын Богд уул”-н бүс хад жалга бартаа саад ихтэй учир аргаль янгир нэлээд элбэг тэдгээрийг дагаад чоно зэрэг араатан амьтад хааяа тааралддаг.

2.6. Гидросеологи

Түмэн айлын чулуун нүүрсний орд нь баруун хойд, хойд талаараа Ац Богд уул (1396.6 м) тэдгээрийн салбар бэсрэг уулс, толгод зүүн хойноосоо баруун урагшаа цувран тогтоно. Зүүн өмнө, өмнөд хэсгээрээ 1038.6 м, 1061.5 м, 1048.1 м, 1041.7 м, 1055.1 м өндөрлөг бүхий толгодоор хүрээлэгдэнэ. Эдгээр нь усны хагалбарын шугамыг илэрхийлэхээс гадна тэжээгдлийн муж болно.

Мөн физик газар зүйн онцлог, газрын гадаргуун ерөнхий байдал, өндрийн ялгаа ямар байгаа зэргээс хамаарч газрын доорх усны байрлал, уст давхаргын зузаан, чулуулгийн ус дамжуулах чадвар, шүүрүүлэх байдал, усан сүлжээ, тэжээгдлийн муж, усны химийн найрлага нь олон янз байна.

2.7. Дэд бүтэц, эдийн засаг, хүн ам:

Мандах сумын нутаг дэвсгэр бүхэлдээ манай улсын дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн хязгаар нутгуудын нэг юм. Сумын төв нь Сайншанд хотоос баруун урагш 170 км зайд байрладаг ба засаг захиргааны анхан шатны нэгж 5 багтай, нийт 1568 /2016он/ хүн амтай. 2017 онд барьж ашиглалтад оруулсан Цагаан суварга-Мандах чиглэлийн 22 кВ-ын цахилгаан дамжуулах шугам талбайн зүүн талаар 4-5 км-ийн зайд өнгөрдөг.

Тус сум нь 132.2 мянган толгой малтай, 1266061 га газар нутагтай нийт нутаг бэлчээрийн зориулалттай ашиглагддаг.

Цагаан суваргын ордыг ашиглахтай холбоотой Оюу толгой-Цагаан суваргын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах 220 кВ-ийн шугамыг барьж ашиглалтад оруулснаар бүс нутгийн цахилгаан хангамжид эергээр нөлөөлсөн. Мөн уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд зориулан говийн бүс нутгаар төлөвлөсөн хэвтээ чиглэлийн төмөр зам Түмэн айлын чулуун нүүрсний ордоос урагш 15 км ойр зайтай байгаа юм.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжиж буй “Их түмэн хүрд” ХХК-ний нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны төлөв байдал, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, тухайн газарт явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн магадлан жагсаах арга, матрицын аргаар тодорхойлсон. Энэхүү үнэлгээгээр:

- БОННУ-ний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох, тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (Checklist)-ыг хэрэглэсэн.
- Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг,

бусад гэсэн 5-н үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар нөлөөллийг “сөрөг”=(-), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3-н бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3-н зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн.

Хүснэгт № 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	шууд	Шууд бус	Өөрөө	Богино	дунд	урт	буцах	буцагтгүй	Бага	дунд	хүчтэй
Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанарөөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон бусад барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас /хөрс хуулалт, олборлолт, овоолго, зам, барилга байгууламж/ хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	-					-		-			-
Хөрс хуулалт, хүдэр олборлолтоос геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-
Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх	-				-			-			-
Бичил уур амьсгал өөрчлөгдөх		-		-			-			-	
Байгалийн нөөц ашиглалт											
Газрын нөөц баялаг	-				-			-			-
Газрын доорх усны нөөц	-				-					-	
Бэлчээрийн нөөц	-				-			-			-
Эрдэс түүхий эдийн нөөц	-				-			-	-		
Эрчим хүчний нөөц			-		-				-		
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Газрын доорх ус бохирдох		-		-			-			-	
Гадаргы усны бохирдол		-		-			-		-		
Агаар бохирдох	-			-			-		-		
Хөрс бохирдох	-				-		-				-
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйлс											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-				-				-		
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-				-				-		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		-			-			-	-		
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	-				-			-	-		
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	-				-			-	-		
Эдийн засаг, нийгмийн асуудал											
Татварын орлого нэмэгдэх	+				+					+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+					+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх	+				+					+	
Ажлын байр нэмэгдэх	+				+					+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-					-	
Нийт	20	5	1	4	17	4	5	8	4	8	8

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 20%, шууд бус нөлөөлөл 5% байна. Нийт нөлөөллийн 8 нь бага эрчимтэй, 5 дунд эрчимтэй, 8 хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна.

Нийт нөлөөллийн 80.8% нь сөрөг, 19.2% нь эерэг нөлөөлөл байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна гэж үзсэн байна.

3.1. Газрын гадаргад үзүүлэх гол нөлөөлөл

Уурхайн бүтээн байгуулалт болон уурхайн үйл ажиллагааны явцад 2024 онд нийт га (нүүрс тээврийн замын талбай орсон) талбайн одоогийн байдал, тухайн газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдсөн.

- Нүүрс олборлох явцад үүсэх уурхайн ухалга буюу карьер, карьераас гарах уурхайн хаягдал овоолго, нүүрсний агуулах, техникийн паркын талбай, тээврийн зогсоол, нүүрс тээврийн болон технологийн замууд хийхэд газрын хэвлийн тогтоц өнөөгийн байгалийн унаган төрх өөрчлөгдөнө.
- Уурхайн технологийн замууд болон нүүрс тээврийн замыг хийж тогтмол усалгаа, арчилгаатайгаар ашигласанаар замын орчмын газрын гадарга дээгүүр олон салаа зам үүсэх нөхцөл багасаж мөн газрын гадаргад сөрөг нөлөө үзүүлэх нь багасна.

3.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Үйл ажиллагааны явцад үүсэх тоос нь нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, усанд үл нордгоос нордог хүртэлх хэмжээтэй хөрс, шорооны нийлмэл шинж чанартай байна. Уурхайн үйл ажиллагаа болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдаж байгаа төслийн талбайн ойр орчимд тоосжилт үүсэх бөгөөд цаг агаар, салхины хурд, газарзүйн онцлог, тээврийн хэрэгслийн төрөл, жин, хурд, нэгж тээвэрлэлтийн хугацаа зэргээс шалтгаалан нөлөөлөл нь ялгаатай байна.
- Тоосжилт өндөртэй газар ажиллаж байгаа хүмүүс, ойролцоо ургамлын бүрхэвч өртөх магадлалтай.

3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Хөрсний физик шинж чанарт өөрчлөлт орно. Төсөл хэрэгжиж байгаа газар нутаг болох говь хээрийн хөрс нь сийрэг бүтэцтэй тоосжилт ихээр үүсгэх нөхцлийг бий болгод. ог тул шороон замын орчимд хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучмал үе үүссэнээр хөрсний хими, физик шинж чанар өөрчлөгдөх, ургамлын бүлгэмдэл өөрчлөлтөнд орох боломжтой.
- Уурхайн ухалгын нөлөөнд өртөж тухайн газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөнө.
- Газрын хэвлий, хөрс нь ахуйн болон үйлдвэрийн бохир усаар дамжин бохирдвол газрын доорх болон гадаргын усанд нөлөөлөх, түүгээр дамжин хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг хам нөлөөлөл үүсэж болзошгүй юм.

3.4. Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Уурхайн ухалгын нөлөөнд өртөх га талбайн одоогийн байдал, тухайн газрын ургамалан бүрхэвч нөлөөлөлд өртөнө.
- Уурхайн үйл ажиллагаа болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны улмаас ургамлан нөмрөгт нөлөөлөх шууд нөлөөлөл нь тоосжилт юм. Төслийн үйл ажиллагааны улмаас үүссэн шороо тоос тухайн газраас хааш хаашаа 50-100 орчим метрт удаан хугацаагаар хадгалагдан үлдэнэ. Үүний улмаас орчны ургамлын навчны амсар хаагдаж, ургамлын навчны хэмжээ жижгэрэх улмаар ургамал бүхэлдээ давжаарч болзошгүй. Ургамлын навчинд бууж тогтсон нарийн ширхэгтэй шороон хучлага, тоос ургамлын амьдрах чадварт сөргөөр нөлөөлнө.
- Уурхайн үйл ажиллагаа болон нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцад машин, техникийн шатах тос, тослох материал алдагдаж хөрс ургамлыг бохирдуулж болзошгүй.

3.5. Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Энэ бүс нутгийн махчин амьтад нь ихэвчлэн шөнийн идэвхтэй тул өдрийн цагаар махчин амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага ба хулан гэх мэт зүйл хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн талбайгаас зайлсхийх магадлалтай.
- Мах идэшт хөхтөн амьтад нь байнгын хөдөлгөөний ачаалалтай автозамуудыг хөндлөн гарахаас зайлсхийх, уурхайн байнгын ажилагааны явцад дуу чимээ, хөдөлгөөнөөс зайлсхийх хандлагатай бөгөөд энэ нь популяцийн тусгаарлалт үүсгэх сөрөг нөлөөтэй.
- Уурхайн байнгын ажиллагаа болон нүүрс тээвэрлэх ажил гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн байнгын шилжилт хөдөлгөөн, дуу чимээ нэмэгдсэнээр ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хумигдана.

3.6. Усан орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл

Их Түмэн Хүрд” ХХК-ийн “Алаг Цав” төслийн нүүрсний уурхайн үйл ажиллагааны явцад гадаргын болон газрын доорхи усанд нөлөөлөх нөлөөлөл нь дундаас бага зэргийн нөлөөлөлтэй байна.

Гэвч ус нь хүн амын амьдралын гол эх үүсвэр тул газрын доорхи нөөцийг ашиглах, үйл ажиллагааны явцад бий болсон бохир ус хүрээлэн буй орчинд тархах, газрын доорхи усанд нэвчих, гадаргын усанд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг нарийн төлөвлөн төслийн хэмжээний усны менежментийн ажиллаж байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Их Түмэн Хүрд” ХХК-ийн “Алаг Цав” төсөл нь Монгол улсын хууль, тогтоол, дүрэм, журам, стандартыг баримталж, хариуцлагатай уул уурхайг Монгол улсад хөгжүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, орон нутагт хөрөнгө оруулалт хийн ажиллаж байна.

Энэхүү төсөл нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, төрийн байгууллагуудын зөвлөгөө зөвлөмж, олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа тусган, компаний байгаль орчны бодлогын хүрээнд байгаль орчны менежментийн системийг боловсруулж, говийн нөхцөлд тохирсон байгаль орчны менежментийн системийг нэвтрүүлж ажиллахыг үндсэн зорилтоо болгон ажиллаж байна.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ

Уурхайн дотоод, гадаад замын усалгааг тогтмол хийж орчны тоосжилтын хэмжээг бууруулах арга хэмжээг авах, автомашины хурдны хязгаарт хяналт тавих, зам талбайг тогтмол усалгаа хийгдэж байна.



Зураг № 6. Уурхайн технологийн замууд



Зураг № 7. Уурхайн технологийн замын хурдны хязгаарлалтын тэмдэг



Зураг № 8. Уурхайн нүүрс тээврийн зам



Зураг № 9. Уурхайн нүүрсний агуулахаас нүүрс салхинд хийсэхээс хамгаалж 2 талаар нь овоолго үүсгэсэн байдал

Уурхайн технологийн замууд, нүүрс тээврийн замаас үүсэх тоосжилтыг багасгах зорилгоор уурхайгаас гарч байгаа занарыг бутлуураар бутлан хайргатай хольж 1 км замд туршилтын ажлын хийж байна.

Замын туршилтын ажлыг 2024 оны 10-р сарын 25-аас хийж эхэлсэн бөгөөд замын материалд занар 500м^3 , хайрган хөрс 230м^3 хольж дэвсэлт хийсэн. Үр дүн нь одоогоор гараагүй байна.





Зураг№ 10. Тоосжилтыг бууруулах 1 км замын туршилтын ажил

Мандах сум орон нутгийн 9,1 км замыг сайжруулах ажил 2024-05-09-аас 2024-05-12 ний өдөр хүртэл нийт өөрөө буулгагч хово 2, автогрейдер 1, ковш 1, туслах техник 2 өдрийн ээлжээр 4 оператор, 2 хариуцсан ажилтан нийт 6 хүн хаягдал хөрсөөр дэвсэлт хийж ажиллав.



Зураг№ 11. Орон нутгийн зам засварын ажил

Хүснэгт № 4. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
1	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Хөдөлгөөнт техникүүдийг жил тутмын техникийн үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол явуулах.	Тогтмол хэрэгжиж байна	Уурхайн машин техникүүдийг жил бүр техникийн улсын үзлэгт оруулж, засвар үйлчилгээг цементэлсэн талбай бүхий Засварын газарт хийгдэж байна. 2024 онд нийт 67 машин, техник тоног төхөөрөмжийг улсын үзлэг хамруулсан.
		Технологийн зам болон хучилтгүй замд тээвэр хийхэд хурдны хязгаар анхааруулсан хориглосон Хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах (Технологийн зам, нүүрс тээврийн зам)	Тогтмол хэрэгжиж байна	Уурхайн технологийн зам, нүүрс тээврийн зам, орон нутгийн замуудад 5,10,20,30,50 км/цагийн хурдны хязгаарлалтын тэмдгүүдийг байрлуулсан. Уурхайн хэмжээнд нийт 74ш тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.
2		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа усалгааг тогтсон хуваарийн дагуу хийх		Технологийн зам, нүүрс тээврийн замын дагуу усалгааг өдөр бүр хийж байна. Зуны улиралд 1-3 удаа Өвлийн улиралд 1 удаа хийгддэг. Мөн замын арчилгааг тогтмол хийж тоосжилт бага үүсгэх материалаар технологийн замын хучилт хийгдсэн. 2024 онд замын усалгаанд 34,436 м3 усыг ашигласан.
3		Технологийн замд 1 км газарт тоосжилт бага үүсэх материалын туршилт хийх		Уурхайгаас гарч байгаа занарыг буталж жижиглэн замын тоосжилт дарах туршилтын ажил 1км замд хийгдэж байна.
		Бүх төрлийн хог хаягдлыг шатаахыг хориглож хяналт тавьж ажиллах		Алаг Цав төслийн талбайд хог хаягдал шатаахыг бүрэн хориглосон. Хог хаягдлыг ангилан ялгаж ахуйн хог хаягдлыг сумын хогийн цэгт тээвэрлэн хүргэж, ландфилдэн булшилж байна. 2024 онд 63 тонн энгийн хог хаягдал сумын хогийн цэгт тээвэрлэн хүргэсэн.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
4		Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын доргилт чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу гүйцэтгэх		2024 онд уулын ажилд заагдсан хүрээнд Бласт ХХК-тай гэрээ байгуулж стандартын дагуу тэсэлгээний ажлыг гүйцэтгэж байна. Тэсэлгээг хийхдээ тэсэлгээний олон улсын болон монгол улсын дүрэм журам, аюулгүй байдал, стандарт шаардлагыг ханган гүйцэтгэдэг.

5.2. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт


Алаг Цав нүүрсний ил уурхай нь ус ашиглах дүгнэлт гэрээний хүрээнд усыг зүй зохистой хэрэглээг бий болгож, усыг хяналттайгаар ашиглах бодлогыг баримтлан ажиллаж байна.

Унд ахуй болон үйлдвэрлэлд хэрэглэж байгаа усны өдрийн дундаж зарцуулалтыг бага байхаар төлөвлөн ус ашиглалтад хяналт тавьж байна.

Ус ашиглалт. 3 худагт тоолуур суурьлуулж өдөр тутамд бүртгэл хөтлөж усны хэрэглээг хянаж байна.

Сарын сүүлд тоолуурын баталжуулалт хийгдэж ус ашигласны төлбөрийг тухай бүрт төлж барагдуулж байна. Зам талбайн усалгаа, унд ахуйд ашигласан усны хэрэглээ

График№ 1. Нийт усны зарцуулалт



Хүснэгт№ 5. Уурхайн ус ашиглалт

№	Сар	Худаг	
		Үйлдвэрлэл (м3)	Унд ахуй (м3)
3	3 сар	919,0	312,0
4	4 сар	919,0	1076,0
5	5 сар	0	536,0
6	6 сар	1228,0	892,0
7	7 сар	4953,0	850,0
8	8 сар	7065,0	1952,0
9	9 сар	8811,0	2181,0
10	10 сар	10541,0	2382,0
Нийт		34436,0	11081,0



Зураг № 12. Малчны худаг, унд ахуйн худгийн байр, тоолууржуулсан байдал

5.3. Усны зохистой ашиглалтын талаар мэдлэг олгох сургалт:

Их Түмэн Хүрд ХХК нь байгаль орчны бодлогын хүрээнд нийт ажилчдын байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг хангах үүднээс мэдлэг олгох сургалтыг нийт ажилчдад орж байна.

Энэ сургалтанд усны менежментийн ерөнхий танилцуулга, усны зөв зохистой хэрэглээ, усны ашиглалт болон хамгааллыг оновчтой байлгахын тулд юу хийх ёстойг тусган нийт ажилчдад хүргэдэг.

БО-ны сөрөг нөлөөллийг бууруулах, орчны бохирдлоос сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, байгаль орчны мэдлэг олгох зорилгоор уурхайн нийт ажилтнуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудыг тогтмол орж байна.

Нийт ажилчдад усыг ариг гамтай хэмнэж ашиглах талаар сургалтыг 2 удаа орсон.



Зураг № 13. Уурхайн ажилчдад БО-ны сургалт орж байгаа нь

Хүснэгт № 6. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
Усны нөөц				
1	Ил уурхайн үйл ажиллагаанд усыг зүй зохистой ашиглах	Уурхайн нийт ажилчдад усны хэрэглээ, зөв ашиглалтын талаар сургалт явуулах	Тогтмол хэрэгжиж байна	Уурхайн нийт ажилчдад шинэ ажилтны сургалтаар ус зүй зохистой ашиглах талаар сургалтыг тогтмол өгч байна. Үүнээс гадна усыг ариг гамтай хэрэглээ, бохирдол үүсгэхгүй байх, нөөцийг хамгаалах талаар сургалтыг жилд 2 удаа олгож байна.
2		Ашиглалтын худаг болон нөлөөллийн бүсийн худгийн ойр орчимд улирал тутам цэвэрлэгээ хийх	Тогтмол хэрэгжиж байна	Уурхайд ашиглаж байгаа худгийн ойр орчимд улирал бүр цэвэрлэгээг хийдэг. Мөн ойр орчмын сайр, уст цэг, малчны худгийн ойр орчимд цэвэрлэгээг хийсэн.
3		Ус ашиглалтын талаар мэдээллийн самбар байрлуулах	Хийгдсэн	
4	Ил уурхайн үйл ажиллагааны улмаас усны нөөц багасгахаас сэргийлэх	Ил уурхайгаар шүүрч буй усыг зам усалгаа, мод усалгаанд дахин ашиглах, шүүрч байгаа усанд тоолуур суурьлуулах, бүртгэл хөтлөх	Тогтмол хэрэгжиж байна	Уурхайн карьераас шүүрлийн ус 2024 оны 09 сараас эхэлж бага хэмжээгээр гарч байгаа ба усыг зүмп хийж носасаар замын тоосжилт дарах усалгаа, мод усалгаанд ашиглаж байна. Шүүрлийн усанд тоолуур суурьлуулсан.
5		Худгийн усны түвшинд хэмжилт хийж, бүртгэл хөтлөх.	Тогтмол хэрэгжиж байна	Худгийн усны түвшинд хэмжилтийн ажлыг тогтмол гүйцэтгэж байна.
6	ШТС болон химийн бодисын асгаралт үүсэхээс сэргийлэх	ШТС болон химийн бодисын асгаралт бий болсон тохиолдолд нэвчүүлэхгүй байх арга хэмжээ авах. Хөрсөнд нэвчилт үүсгэхгүй байхад хяналт тавих.	Тогтмол хэрэгжиж байна	ШТС-ыг стандартын дагуу гүйцэтгэж асгаралт болсон тохиолдолд хөрсөнд нэвчихгүй цементэлсэн хувилаар худагт цугларахаар хийгдсэн. Бусад машин техникийн засвар үйлчилгээ хийх талбай, хог хаягдлыг ангилан ялгах талбай болон ШТМ-ын агуулах зэрэг хөрсөнд ШТМ болон бодис асгарахаас сэргийлж хөрснөөс тусгаарлаж бетонон хучилт хийсэн.
7		Ус ашиглалтын гэрээ байгуулж, усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Хийгдсэн	2024 онд ашиглах усны дүгнэлтийг Галба, Өөш Долоодын сав газраар гаргуулж, Сумын Засаг даргатай ус ашиглах гэрээг байгуулсан. Усны төлбөрт 4,864,250 төгрөгийн төлбөр төлсөн.


5.4. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр

Төслийн үйл ажиллагаа, ялангуяа ил уурхайн олборлох үйл ажиллагаанд ТЭЗҮ-д заасан хэмжээнээс илүү хэмжээний газрын эвдрэл үүсгэхгүй байх.

Ухаш үүсгэж овоолго тавихдаа ТЭЗҮ-д заасан ажлын дараалал, технологийн горимыг баримтлан ажиллаж байна.



Зураг № 14. Ил уурхайн уурхайн ухаш (карьер)



5.5. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт

Технологийн замуудад тоосжилт бага үүсгэх материалаар дэвсэлт хийсэн. Зам арчилгаа, усалгааг тогтмол хуваарийн дагуу хийж ашиглаж байна.

Шимт хөрсийг холбогдох стандартад заасны дагуу 20-30 см-ийн зузаантай хуулж тусгайлан овоолго үүсгэн хадгалсан.

Зөвшөөрөлгүйгээр газар хөндөгдөж, хөрс эвдрэлд орохоос сэргийлж газар хөндөх зөвшөөрлийн журмыг хэрэгжүүлж ажилласан. Үйл ажиллагаа явуулсан хугацаанд 23 удаа газар хөндөх зөвшөөрөл олгож, 61,4 га эвдрэлд өртөж бүртгэн баримтжуулсан.

		Баталсан өгнө: 2023	Өргөснийг дугар-81	Хуудас 1/2
ИИХ 384-007-ГАЗАР ХОНДХО ЗӨВШӨӨРИЙН МАЛТ				
ГАЗАР ХОНДХО ЗӨВШӨӨРӨЛ				
Зөвшөөрлийн №: 04	Зардал: 100 сурвалж хураар 1100х тэрийн цаанг дээр зурвалж			
Зөвшөөрөл хүсэгчийн нэр: /Хүснэгт/	Албан тушаал: /Хүснэгт/	Огноо: 2023/05/28		
Эхлэх өдөр: 2023/05/28	Дусах хугацаа: 2023/05/30 - өдөр	Хондхон газрын байршил: /Хүснэгт/		
А-ын шардлага: 1. Зомын хадгэлгэний хаас 2. Тусархай амант түүт лавх 3. Долоонхон байх 4. Агаарын дуурайг ойрхон эхэх 5. Буцаа /Хүснэгт/		Тийн ☐ Үгүй ☐ Тийн ☐ Үгүй ☐	Тийн ☐ Үгүй ☐ Тийн ☐ Үгүй ☐	
Зөвшөөрөл олгосон: Үгүй гарын үсэг зурж зөвшөөрөл олгоно. /Хондхон газрын зургийг хавсаргасан байна/				
1. Шахлаганы хэсгийн дугаар: Шахлаганы далай монтатэй эхэх: Тийн ☐ Үгүй ☐	2. Маркшейдер тэмдэглэлийн нэмгээр: Хондхон газрын байршил зургийг гаргасан эхэх: Тийн ☐ Үгүй ☐	3. Байгаль орчны тэмдэглэлийн нэмгээр: Ерөнхий дүгнэлт: /Хүснэгт/	4. Уурхайн дарга: /Хүснэгт/	
Хондхон тухайн хондхон газарт шахлаганы амант нэг монтат хийгдэх эхэх: Тийн ☐ Үгүй ☐	Хондхон газрын шимт хөрөнгийн хэмжээг /м³/ 17833.3 м³ Хондхон газрын хөрөнгийн хэмжээг /м³/	Фото зураг авах: /Хүснэгт/		
Зөвшөөрөл олгосон албан тушаалын нэр: /Хүснэгт/	Зөвшөөрөл олгосон албан тушаалын нэр: /Хүснэгт/	Зөвшөөрөл олгосон албан тушаалын нэр: /Хүснэгт/	Зөвшөөрөл олгосон албан тушаалын нэр: /Хүснэгт/	
Гарын үсэг: /Хүснэгт/	Гарын үсэг: /Хүснэгт/	Гарын үсэг: /Хүснэгт/	Гарын үсэг: /Хүснэгт/	
Гүйцэтгэл: Хондхонд ахал ажлынгуудын гарын үсэг зурж уах ажлын зөвшөөрлийг олгоно. Маталт хийх гарын зургаг бүх гарын тэмдэглэл, хадгэлсэн үйлчилгээ, утгаар болон бусад суурилуулалт зэргийг харуулсан байна.				

Зураг № 16. Газар хөндөх зөвшөөрлийн маягт

2024 он							
№	Зөвшөөрлийн дугаар	Зөвшөөрөл хүсэгчийн албан тушаал	Зөвшөөрөл хүсэгчийн нэр	Газар хөндөх шалтгаан	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хөндөх газрын байршил
1	32	Агуулах хариуцсан ажилтан	Гончигжав	Б4-н газар бэлтгэх	2024.03.21	2024.06.01	Пүүний агуулахын зүүн тал
2	33	Уурхайн орлогч дарга	Баяржаргал	Нүүрс тээврийн ШТС-н барих газар	2024.03.23	2024.03.25	Нүүрс тээврийн замын урд хэсэгт
3	1	Уулын мастер	Б.Баяржаргал		2024.04.01	2024.04.10	Нүүрсний талбай
4	34	Кемп менежер	Н.Хурца	Кемпийн хашаанд машины зогсоол	2024.04.01	2024.04.10	Кемп
5	35	Уулын мастер	Ганхүү	Отвалийн өргөтгөл	2024.04.02	2024.06.30	Отвалийн өргөтгөл
6	36	Кемп менежер	Баянсан	Гэрүүдийн хооронд дулааны шугам татах	2021.08.26		Кемпийн зүүн талд ажилчдын гэр
7	37	Кемп менежер	Баянсан	Хятад гал тогооны бохирын шугам	2024.09.13		Хятад гал тогооны баруун талд
8	38	Уулын мастер	Г.Баатархүү	2 дугаар овоолгын тэлэлт	2024.10.09	2024.10.10	2-р овоолгын зүүн урд талд
9							

Зураг№ 17. Газар хөндөх зөвшөөрөл олгосон бүртгэл



Зураг№ 18. Засварын газар, ШТС, Шатах тослох материалын агуулах хөрс бохирдохоос сэргийлж цементэн хучилттай болгосн байдал



АСГАРАЛТЫГ МЭДЭЭЛЭХ, ЦЭВЭРЛЭХ ЖУРАМ				
Уялсан	Нэр	Албан тушаал	Журамд оруулах санал	Гарын үсэг
Баталсан:	Баталсан	Гүйцэтгэх захирал		
Хянасан:	Баталсан	Хуулийн зөвлөх		
Хянасан:	С.Алтэнгэрэл	Алаг Цав төслийн Уурхайн дарга		
Боловсруулсан:	Ц.Ганзориг	ХАБЭАБО харууцсан менежер		

Баталсан, өөрчилсөн байдлын бүртгэл				
Өөрчлөлтийн №	Хүчинтэй болсон огноо	Өөрчилсөн хуудасны дугаар	Өөрчилсөн шалтгаал	Баталгаажуулалт

Зураг № 19. ШТС, Засварын газарт байрлуулсан асгаралтын иж бүрдэл, асгаралтын журам мөрдөн ажилладаг

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
	Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр			
1 2	Ил уурхайн үйл ажиллгааны явцад асгаралт үүсч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах. Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах	Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Тогтмол хэрэгжиж байна	Засварын газар, ШТС болон бусад шатах тослох материал хэрэглэж хадгалж байгаа талбайд АБҮ-ийг тогтмол хийж, асгаралтаас сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Асгаралт болсон тохиолдолд шуурхай мэдээлэх, асгаралтыг цэвэрлэж саармагжуулах журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Асгаралтын үед ашиглах иж бүрдлийг ШТС, ШТМ-ын агуулах, Засварын газарт тус бүрт байрлуулж ашиглаж байна.
		Газарзүйн мэдээллийн системд шимт, хөрсний овоолгуудын байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах, тухайн овоолгуудыг газар дээр нь хаягжуулах	Тогтмол хэрэгжиж байна	Уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орж байгаа талбайн шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хуулан авч овоолго үүсгэн хадгалж байна. 2024 онд нийтга талбай эвдрэлд орж, нийт.....м3 шимт хөрс хуулж стандартын дагуу хадгалсан.
3	Уурхайн хүнд даацын техникийн хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авч хяналт тавих	Тогтмол хэрэгжиж байна	Шимт хөрс хуулалт хийхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл авч, уурхайн нэгдсэн мэдээллийн санд бүртгэж, хуулалт хийгдсэний дараа хэмжилт хийгдэж байна. 2024 онд 8 удаа газар хөндөх зөвшөөрөл авагдсан.
4	Хог хаягдлаар хөрсөнд бохирдол үүсэх	Хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлын түр цэгүүдийг хөрснөөс тусгаарлаж цементлэх	Тогтмол хэрэгжиж байна	Ахуйн болон аюултай хог хаягдал түр хадгалах, ангилан ялгах цэгийг хөрснөөс тусгаарлаж цементэлж хучилт хийсэн.

5.6. Ургамалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “Алаг Цав” төслийн нүүрсний ил уурхайн талбайд үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хэрэгжүүлэгч болон бүх гэрээт, туслан гүйцэтгэгч байгууллагууд түүний ажилтнууд дагаж мөрдөх Байгаль орчны дотоод журмуудыг боловсруулан хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээг авч ажилласан.

Ургамлын судалгаа мониторингийн ажлыг Эм Эс Си Эйч Гранд Нексус ХХК-ийн ургамал судлаач, мэргэжилтнүүдтэй хамтран уурхайн лицензийн талбай, нөлөөллийн бүсэд гүйцэтгэв.



Зураг № 20. Төслийн талбайн ургамлын мониторингийн судалгаа

Уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд өртөх талбайн ургамалжилтын судалгааг хийхэд Нүүрсний агуулахын орчимд шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст цөлөрхөг хээрийн бүлгэмдэлийн тусгагын бүрхэц нь 30% бөгөөд 1м² талбайд 7 зүйл ургамал тохиолдоно. Сайрын хялгана - 15%, Зүүн гарын хазаар өвс - 10%, хөмөл -5%, дагуур хүж өвс -3%, харин нэг наст гурван зүйл ургамал -5% -ийн бүрхэцтэй байна.

Хүснэгт № 8. Нүүрсний агуулах урд талд хийгдсэн ургамлын бичиглэл (1 м²-ийн ургамал)

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг	Арви	Бүрхэц %
1	<i>Stipa glareosa</i> P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн	Сор	15

2	Cleistogenes songorica (Roshev.) Ohwi.	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	үетэн	Cop	10
3	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	Олон наст	Өвслөг	Алаг өвс	Sp	5
4	Haplophyllum dauricum (L.) G. Don	Дагуур хүж өвс	Олон наст	Өвслөг	Үетэн	Sp	3
5	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	Нэг наст	Өвслөг	Үетэн	Sol	2
6	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Sol	1
7	Eragrostis minor Host	Бага хургалж	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Sol	2

Хүснэгт № 9. Ургамлан нөмрөг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
1	Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд ургамал өртөж болзошгүй	Шимт хөрс хуулах талбайн ургамлан бүрхэвчийн мэдээллийг бүртгэх, ажиглах.	Хийгдсэн	2024 онд мэргэжлийн байгууллагатай хамтран Ботаникийн хүрээлэнгийн ургамал судлаач Сэмжидээр ургамалжилтын судалгааг хийлгэсэн. Байгаль орчны мониторингийн тайлангаас үзнэ үү.
2	Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж байгаа эсэхэд мониторинг хийх	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүдийг сонгон авч ургамлын бүлгэмдлийн харьцуулсан судалгаа хийх	Хийгдсэн	2024 онд мэргэжлийн байгууллагатай хамтран Ботаникийн хүрээлэнгийн ургамал судлаач Сэмжидээр ургамалжилтын судалгааг хийлгэсэн. Байгаль орчны мониторингийн тайлангаас үзнэ үү.

5.7. Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн арга хэмжээний биелэлт

- Энэ бүс нутгийн махчин амьтад нь ихэвчлэн шөнийн идэвхтэй тул өдрийн цагаар махчин амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага ба хулан, хар сүүлт зээр зэрэг хөхтөн амьтдын тархац, байршил, тоо толгойг тогтоох ажиглалт судалгаа хийх, хур бороо багатай улиралд худаг уст цэг үүсгэж амьтдыг услах арга хэмжээг авах, өвлийн улиралд байршил нутагт өвс тавих биотехнологийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлууд хийгдсэн.
- Төслийн талбайд олон салаа зам гаргах ан амьтдын үргээх дуу чимээ их гаргахаас зайлсхийх
- Уурхайн бүсэд ан амьтан орохоос хамгаалж торон хашаа барьсан
- Ан амьтны мониторинг судалгааг байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Эм Эс Си Эйч Гранд Нексус” ХХК-тай гэрээ байгуулж мэргэжлийн багш судлаачдаар хийлгэн, ан амьтдад учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.
- Уурхайн ажилчдын хотхоны баруун талд мал ан амьтдад зориулан гаргасан хиймэл нуур буюу уст цэгийг байгуулж зөөврөөр усыг тогтмол дүүргэж ан амьтад усалгаа биетехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Зураг№ 21. Төслийн талбайд байрлах Хулангийн сүрэг уст цэгээс тогтмол ус уудаг



Зураг№ 22. Төслийн талбай орчимд Хулангийн 4-5 сүрэг тархан байрладаг



Зураг № 23. Арван Наймын богд уулын орчимд Аргалын сүрэг

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг жилт	Гүйцэтгэл
Ам амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
1		Уурхайн олборлолт явуулж буй хэсгийг хашиж, ан амьтан орж өртөхөөс сэргийлэх	Хийгдсэн	2023, 2024 онуудад уурхайн олборлолт явуулж буй талбайд ан амьтнаас хамгаалж хашаа барьсан. Нийткм газар хашаа барьж хамгаалсан.
2	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр амьтдын амьдрах орчинд нөлөөлөх	Тээврийн замын дагуу хулан, цагаан зээр, хар сүүлт зэрэг амьтдын шилжил хөдөлгөөнийг судалж шаардлагатай зам хөндлөн гарч байгаа хэсгүүдэд хурдны хязгаарын тэмдэг, анхааруулах тэмдэглэгээ байрлуулах	Хийгдсэн	Нүүрс тээврийн зам дагуу ан амьтан зам хөндлөн гарч байгаа байршилд мал, ан амьтан замаар гарах анхааруулсан тэмдэг байрлуулж хурдны хязгаарлалтын тэмдэг байрлуулсан.
3	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих	Туруутан амьтдын байршил тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөлхөгчдийн зүйлийн бүрдэлд дуу чимээ нөлөөлж буйг ажиглалт судалгаа хийх	Хийгдсэн	Ан амьтны судалгааг уурхайн нөлөөллийн бүсэд 2024 оны 10 сарын 11-13-ний өдрүүдэд байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Эм Эс Си Эйч гранд нексус” ХХК-ийн амьтан судлаач, биологич нартай хамтран хийсэн. Байгаль орчны мониторингийн тайланд дэлгэрэнгүй оруулсан.
4	Хууль бусаар ан агнах	Нийт ажилчдыг ан амьтдыг хамгаалах, хууль бусаар агнахаас сэргийлэх сургалтад хамруулах.	Хийгдсэн	Ан амьтдыг хууль бусаар агнах, амьтдыг байршил газраас үргэхгүй байх, хайрлан хамгаалах талаар сургалтыг нийт уурхайн ажилчдад байгаль орчны сургалтаар олгож байна.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Их Түмэн Хүрд ХХК нь газрыг зөв зохистой ашиглахтай холбоотой Монгол Улсын хууль, тогтоомжуудын шаардлагууд, байгаль орчны стандартууд, Алаг Цав төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлагууд, компаний дотоод журмын дагуу уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан газар шорооны ажил хийгдэхээс өмнө шимт хөрс хуулах зөвшөөрөл авах ба хуулах шимт хөрсний зузаан, зөөж байрлуулах овоолгыг хэлбэржүүлэх зэргийг журам, заавар, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд орсон газруудад газар хөндөх зөвшөөрлийн журмыг хэрэгжүүлж MNS 5916:2008 стандартын дагуу шимт хөрсийг хуулалт хийж овоолго үүсгэн хадгалсан.

Хүснэгт № 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
Техникийн нөхөн сэргээлт				
1	Хөрсний овоолго үүсгэх	Шимт хөрсний овоолго үүсгэн хэлбэржүүлэх.	Хэрэгжиж байна	2024 онд Алаг Цав уурхайд олборлолт, уурхайн үйл ажиллагаанаас нийт 83,4 га талбай эвдрэлд орж, нийт 37503,0 м ³ шимт хөрс хуулж шимт хөрсний овоолгод хэлбэршүүлэн хадгалсан.
Биологийн нөхөн сэргээлт				
2	“1 тэрбэм мод” хөтөлбөрийн хүрээд мод тарих, ногоон байгууламж бий болгох	Уурхайн бүс, ажилчдын хотхонд мод тарих	Хийгдсэн	2024 онд нийт 1550ш модыг уурхайн бүс, ажилчдын кемп орчимд тарьж, арчлан ургуулж байна. Ургалтын хувь 90-аас дээш хувьтай байна.
3	Хөрсний овоолгыг ургамалжуулах, мод тарих туршилт хийх	Туршилтын талбай байгуулан тарилт хийх.	Хэрэгжиж байна	Уурхайн хаягдал хөрсний овоолго дээр 100*20 м газарт шимт хөрсийг малын бууцтай 1/3 хэмжээгээр хольж талбай бэлтгэн мод тарих, ургамал тарих туршилтын талбай байгуулж туршилтын ажлыг эхлүүлсэн. Туршилтын талбайд хайлаас, жигд моды 108ш мод тарьсан. Олон наст царгасыг туршилтын талбайд тарьсан. 2025 онд үргэлжлүүлэн хийгдэнэ.

Хүснэгт № 11. Шимт хөрсний хуулалт, хэлбэршүүлэлт

№	Овоолгын ангилал	2023 онд хуулагдсан шимт хөрсний овоолгын хэлбэршүүлэлт (м3)	2024 онд хуулагдсан шимт хөрсний овоолгын хэлбэршүүлэлт (м3)
1	I-р овоолго	28344,0	15463,0
2	II-р овоолго	42837	22040,0
Нийт		71181,0	37503,0



Зураг № 24. Нүүрсний агуулах шимт хөрс хуулалт



Зураг № 25. Уурхайн технологийн замын шимт хөрс хуулалт

Биологийн нөхөн сэргээлтийн туршилтын ажил: 2024 онд БОМТ-нд туссан биологийн нөхөн сэргээлтийн туршилтын ажлын хүрээнд хаягдал хөрсний овоолгод туршилтын талбай байгуулж мод тарих, олон наст ургамал тарих туршилтын ажлыг гүйцэтгэсэн.

Туршилтын талбайг байгуулахдаа шимт хөрсийг малын бууцтай 1/3 харьцаагаар хольж хөрсний үржил шимийг сайжруулан 50 см-ийн зузаантай дэвсэлт хийсэн. Мөн тойруулж салхинаас хамгаалж хамгаалалтын далан хийсэн. (Туршилтын талбайг Зураг № 24-өөс үзнэ үү)

Туршилтын талбайд хайлаас, улиас, жигд, сухай 4 төрлийн 108 ш мод, шар царгасыг үрээр тарьж биологийн нөхөн сэргээлтийг хийсэн. 2025 онд нэг наст болон олон наст ургамал, тухайн нутагт зонхилон ургадаг ургамлын тарих туршилтын ажил үргэлжлэн хийгдэнэ.



Зураг № 26. Хаягдал хөрсний овоолго дээр биологийн нөхөн сэргээлт хийсэн туршилтын талбай



Зураг № 27. Хаягдлын овоолго дээрх туршилтын талбайд шимт хөрсийг бордоотой хольж дэвсэлт хийж байгаа нь

Монгол улсын ерөнийлөгчийн санаачлагаар хэрэгжиж байгаа “Нэг тэрбум мод хөтөлбөр”-ийн хүрээнд уурхайн ажилчдын хотхон, хаягдал хөрсний овоолго, ШТС, Засварын газар, нүүрсний агуулахын эргэн тойронд 1550 ш модыг хавар, намрын тарилтаар тарьж арчлан ургуулж байна

2023-2024 онуудад нийт мод тарьж, тарьсан модны усалагаа, арчлалт, хамгаалалтыг үр дүнтэй хийснээр модны ургалт 90%-иас дээш хувьтай ургалттай байна.

Тарьсан модны төрөл: 2024 онд: Гоёлын улиас-300ш, Жигд-1050, Хайлаас-100, Улиас-100 тус тус тарьсан. Нийт 2023-2024 онд 2750ш мод тарьж, арчлан ургуулж байна.



Зураг№ 28. Мод тарьсан талбай



Зураг№ 29. Модны усалгаа арчлалтыг тогтмол хийж байна.



Зураг№ 30. Тарьсан модны ургалтын байдал

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт №12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
1	Төслийн талбайн ойролцоо талбайд ан амьтан услах хөв цөөрөм байгуулах	Дорноговь аймаг, Мандах сум, уурхайн нөлөөллийн бүс	Бүрэн хэрэгжсэн	Уурхайгаас 1,5 км-т мал ан амьтдад зориулсан хөв цөөрмийг байгуулж усыг зөөврөөр тогтмол нуурыг дүүргэж ан амьтан, нөлөөллийн бүсийн малын усалагааг хийж байна.
2	Мандах суманд нутагт гар аргаар олборлолт хийгээд нөхөн сэргээлт хийгдээгүй хаягдсан талбайд дүйцүүлэн техникийн нөхөн сэргээлт хийх	Дорноговь аймаг, Мандах сум, 2-р багт	Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт	Мандах сумын 2-р багийн нутагт Боомт гэх газарт гар аргаар алт олборлогчдын эвдэж сүйтгээд нөхөн сэргээлт хийгээгүй газарт орон нутгийн иргэдтэй гэрээ байгуулж, заавар зөвлөмж өгч техникийн нөхөн сэргээлт хэлбэршүүлэлтийн ажлыг гүйцэтгэлээ. Техникийн нөхөн сэргээлтийг сумын Засаг даргад хүлээлгэн өгсөн.


7.1. Төлөвлөгөөний хэрэгжилт:

Уурхайн нөлөөллийн бүсэд ан амьтанд зориулж байгалийн тогтцод тулгуурлан хонхор ус тогтдог хэсэгт нуур үүсгэн хур бороо багатай хавар, намар, зуны улиралд усны машинаар ус зөөвөрлөн дүүргэж мал, ан амьтныг услах биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэхүү ажил нь 2023-2024 онуудад хийгдээд явж байна. Цаашид нуурын эргийг тохижуулах, ан амьтны хөдөлгөөнт камер суурьлуулах ажлыг дараагийн жилүүдэд хийхээр төлөвлөн ажиллаж байна.




Зураг№ 31. Ан амьтад зориулсан хөв цөөрөм байршил (Уст цэг уурхайгаас 1.5 км-д)



Зураг№ 32. Мал ан амьтад зориулсан хөв цөөрөм (хиймэл нуур)

Мандах суманд нутагт гар аргаар олборлолт хийгээд нөхөн сэргээлт хийгдээгүй хаягдсан талбайд дүйцүүлэн техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн иргэдтэй гэрээ байгуулан техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг№33. Мандах сумын нутаг Боомт гэх газарт эвдэрсэн талбайг нөхөн сэргээж суманд хүлээлгэн өгсөн



Зураг№34. 2-р багийн нутагт дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээх талбай



Зураг№ 35. Нөхөн сэргээлт хийгдсэний дараа

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Их Түмэн Хүрд ХХК-ийн “Алаг Цав” нүүрсний ашиглалтын талбай орчимд малчин айл өрхийн өвөлжөө, хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

Алаг Цав уурхайн нөлөөллийн бүсэд байгаа айл өрхүүдтэй хамтран ажиллаж байна.

Орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд:

Орон нутгийн нөлөөллийн бүсэд амьдардаг иргэдээс 26,1 сая төгрөгийн 1,8 тн мах худалдан авч иргэдийн амжиргааг дэмжин ажилласан.

- Түмэн айл Инвест ХХК, Түмэн Айл Инвест ХХК-ын Дорноговь аймаг дахь салбар, Их Түмэн Хүрд ХХК-иуд нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд өвөлжөө хаваржааны өтөг бууц цэвэрлэх, хог хаягдлыг цэвэрлэх болон бусад ажлуудад зориулж хамтын ажиллагааны хүрээнд CHUMU 936 ковшыг худалан авч сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.
- Сумын хогийн цэгийг техник гарган булах ажлыг улирал бүр хийу байна. Суманд хогны машины засвар үйлчилгээг хийж өгсөн.
- Мандах сумын 4-р багийн иргэдэд 20тн нүүрсээр хангасан
- Сумын иргэд, сурагчдыг уурхай танилцуулах аяллыг зохион байгуулж уурхайн үйл ажиллагааг, байгаль орчин, сум орон нутагт хийгдэж байгаа ажлуудыг танилцуулсан.



Зураг №36. Орон нутагт хүлээлгэн өгсөн ковш



Хүснэгт № 13. 4-р багийн иргэдэд хүлээлгэн өгсөн нүүрс

9. ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ШУА-ийн Археологийн хүрээлэнгээр 2017 онд археологийн хайгуул судалгааны ажлыг уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэсэн. Судалгаагаар уурхайн ашиглалт явуулах лицензийн талбайд түүх соёлын дурсгал илрээгүй.

Хүснэгт №14. Түүх, соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
1	Уурхайн олборлолтын үед соёлын биет болон биет бус өв илэрсэн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авах	Үйл ажиллагааг зогсоож холбогдох төрийн байгууллагад мэдээлэх	Хэрэгжиж байна	Уурхайн олборлолтын үед соёлын биет болон биет бус өв илэрсэн тохиолдолд үйл ажиллагааг тэр зогсоож холбогдох төрийн байгууллагад мэдээлэх журам, бодлого баримтлан ажиллаж байна. 2024 онд уурхайн үйл ажиллагаа явуулах хугацаанд соёлын биет болон биет бус өв илрээгүй болно.
2	Түүх соёлын өвийг хамгаалах	Соёлын өвийг хамгаалах сургалт нийт ажилчдад орох	Тогтмол хэрэгжиж байна	Байгаль орчны сургалтаар нийт ажилчдад соёлын өвийн тухай сургалтыг тогтмол өгч байна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Уурхайн төслийн талбайд явагдаж байгаа бүх ажлын талбай, үйл ажиллагаанд байгаль орчны осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны үзлэг, шалгалтуудыг тогтмол хийж осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.
- Уурхайн бүтээн байгуулалтын явцад онцгой, хортой химийн бодис ашиглагдахгүй. Ашигласан тос хадгалах сав бүхий талбайг үл нэвчүүлэх материал /хальс/ хатуу хучилт бүхий суурь, хүрээг тойруулсан хөмсөгтэйгээр байгуулж тосыг хөрсөнд нэвчихээс сэргийлэх арга хэмжээг авч хадгалж байна.
- ХАЛМ-ийг нийт ажилчдад танилцуулж, сургалт зөвлөгөө орж, зааварчилгааг өгч ажилладаг.
- Хөрсөнд шатах тослох материалын бохирдол үүсэхээс сэргийлж техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх Засварын газар, ШТМ-ын агуулах, Шатахуун түгээх станц, хогийн түр цэгүүдийг хөрснөөс тусгаарлаж цементэлж хийсэн.
- ШТМ асгарсан үед яаралтай шингээж цэвэрлэж авах асгаралтын иж бүрдлийг 2ш-ийг Засварын газарт байрлуулсан.

- Гал түймрийн аюулаас сэргийлэх, гамшиг ослын үед ажиллах, аврах ажиллагааны талаарх сургалтыг нийт ажилчдад “Уул уурхайн аврах алба”-тай хамтран зохион байгуулж ажилчдаа аюул эрсдэлээс сэргийлэх чадавхийг дээшлүүлсэн.
- ХАБЭА-н осол аваараас урьдчилан сэргийлэх сургалт, заавар зөвлөмж, сэрэмжлүүлгийг тогтмол өгч, осол тохиолдол гарсан тохиолдолд бүртгэн шуурхай мэдээлж, хариу залруулах арга хэмжээг авч ажиллаж байна.



Зураг № 37. Галын сарай, галын хорыг уурхайн обьектуудад байрлуулсан байдал


Галын хорны үзлэг						
Шалтгаан Огноо		М. Дэлгэр, М.Б.Батбаяр 2024.04.03 /2024.04.03/				
№	Байршил	Цогцтой эсэх	Резин хөөлэй	Барууд	Бүртгэл ний шоого	Нэмэлт тэмдэглэл
1	агуулс. хэр. 1	-	-	-	-	-
2	агуулс. хэр. 2	-	-	-	-	-
3	агуулс. хэр. 3	-	-	-	-	-
4	агуулс. хэр. 4	-	-	-	-	-
5	агуулс. хэр. 5	-	-	-	-	-
6	агуулс. хэр. 6	✓	✓	✓	✓	-
7	агуулс. хэр. 7	✓	✓	✓	✓	-
8	агуулс. хэр. 8	-	-	-	-	-
9	агуулс. хэр. 9	-	-	-	-	-
10	агуулс. хэр. 10	-	-	-	-	-
11	агуулс. хэр. 11	-	-	-	-	-
12	агуулс. хэр. 12	-	-	-	-	-
13	агуулс. хэр. 13	-	-	-	-	-
14	агуулс. хэр. 14	-	-	-	-	-
15	агуулс. хэр. 15	-	-	-	-	-
16	агуулс. хэр. 16	✓	✓	✓	✓	-
17	агуулс. хэр. 17	✓	✓	✓	✓	-
18	агуулс. хэр. 18	-	-	-	-	-
19	агуулс. хэр. 19	-	-	-	-	-
20	агуулс. хэр. 20	-	-	-	-	-
21	агуулс. хэр. 21	-	-	-	-	-
22	агуулс. хэр. 22	-	-	-	-	-
23	агуулс. хэр. 23	✓	✓	✓	✓	-
24	агуулс. хэр. 24	✓	✓	✓	✓	-
25	агуулс. хэр. 25	✓	✓	✓	✓	-
26	агуулс. хэр. 26	-	-	-	-	-
27	агуулс. хэр. 27	-	-	-	-	-
28	агуулс. хэр. 28	-	-	-	-	-
29	агуулс. хэр. 29	-	-	-	-	-
30	агуулс. хэр. 30	-	-	-	-	-
31	агуулс. хэр. 31	✓	✓	✓	✓	-
32	агуулс. хэр. 32	✓	✓	✓	✓	-
33	агуулс. хэр. 33	✓	✓	✓	✓	-
34	агуулс. хэр. 34	✓	✓	✓	✓	-
35	агуулс. хэр. 35	✓	✓	✓	✓	-
36	агуулс. хэр. 36	-	-	-	-	-
37	агуулс. хэр. 37	-	-	-	-	-

Галын хорны үзлэг						
Шалтгаан Огноо		М. Дэлгэр, М.Б.Батбаяр 2024.04.03 /2024.04.03/				
№	Байршил	Цогцтой эсэх	Резин хөөлэй	Барууд	Бүртгэл ний шоого	Нэмэлт тэмдэглэл
1	агуулс. хэр. 1	✓	✓	✓	✓	-
2	агуулс. хэр. 2	✓	✓	✓	✓	-
3	агуулс. хэр. 3	✓	✓	✓	✓	-
4	агуулс. хэр. 4	✓	✓	✓	✓	-
5	агуулс. хэр. 5	✓	✓	✓	✓	-
6	агуулс. хэр. 6	✓	✓	✓	✓	-
7	агуулс. хэр. 7	✓	✓	✓	✓	-
8	агуулс. хэр. 8	✓	✓	✓	✓	-
9	агуулс. хэр. 9	✓	✓	✓	✓	-
10	агуулс. хэр. 10	✓	✓	✓	✓	-
11	агуулс. хэр. 11	✓	✓	✓	✓	-
12	агуулс. хэр. 12	✓	✓	✓	✓	-
13	агуулс. хэр. 13	✓	✓	✓	✓	-
14	агуулс. хэр. 14	✓	✓	✓	✓	-
15	агуулс. хэр. 15	✓	✓	✓	✓	-
16	агуулс. хэр. 16	✓	✓	✓	✓	-
17	агуулс. хэр. 17	✓	✓	✓	✓	-
18	агуулс. хэр. 18	✓	✓	✓	✓	-
19	агуулс. хэр. 19	✓	✓	✓	✓	-
20	агуулс. хэр. 20	✓	✓	✓	✓	-
21	агуулс. хэр. 21	✓	✓	✓	✓	-
22	агуулс. хэр. 22	✓	✓	✓	✓	-
23	агуулс. хэр. 23	✓	✓	✓	✓	-
24	агуулс. хэр. 24	✓	✓	✓	✓	-
25	агуулс. хэр. 25	✓	✓	✓	✓	-
26	агуулс. хэр. 26	✓	✓	✓	✓	-
27	агуулс. хэр. 27	✓	✓	✓	✓	-
28	агуулс. хэр. 28	✓	✓	✓	✓	-
29	агуулс. хэр. 29	✓	✓	✓	✓	-
30	агуулс. хэр. 30	✓	✓	✓	✓	-
31	агуулс. хэр. 31	✓	✓	✓	✓	-
32	агуулс. хэр. 32	✓	✓	✓	✓	-
33	агуулс. хэр. 33	✓	✓	✓	✓	-
34	агуулс. хэр. 34	✓	✓	✓	✓	-
35	агуулс. хэр. 35	✓	✓	✓	✓	-
36	агуулс. хэр. 36	✓	✓	✓	✓	-
37	агуулс. хэр. 37	✓	✓	✓	✓	-

Зураг № 38. Галын хор шалгасан үзлэгийн хуудас




Зураг № 39. ХАБЭА-н мэдээллийн самбар



Зураг №40. Алаг Цав төслийн кемп, Засварын газарт, ШТС-т галын самбар, сарай байрлуулсан



Зураг№ 41. Төмөр замын гарам дээр хаалт хийж машин техникийн аюулгүй байдлыг хангасан байдал



Зураг№ 42. ХАБЭА-н сургалтууд, БО-ны сургалт, ХАЛМ-ын сургалт

Хүснэгт №15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсох	Цаг агаарын урьдчилсан мэдээг 5 хоногийн давтамжтай авч мэдээлэх.	Тогтмол хэрэгжиж байна.	Алаг Цав төслийн ажилчдын цахим групп болон мэдээллийн самбарт цаг агаарын мэдээг тотмол мэдээлж байна. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хүчтэй салхи шороон шуурга, хур борооны үед уурхайн үйл ажиллагааг зогсоох, холын аяллыг зогсоох арга хэмжээг авдаг. 2024 онд цаг агаарын саатлаас уурхай 13 удаа зогсолт хийсэн.
2	Уурхайн ажилчдад химийн бодисын нөлөөлөөс урьдчилан сэргийлэх	ХАЛМ-ын сургалт орох	Тогтмол хэрэгжиж байна.	Уурхайн нийт ажилчдад Химийн бодисын аюул эрсдэлээс сэргийлэх сургалтыг хийж, ХАЛМ танилцуулсан.
3	Галын аюулаас сэргийлэх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Тогтмол хэрэгжиж байна.	Гал түймрээс сэргийлэх сургалт орж, гал унтраах дадлага сургуулилт хийсэн.
4		Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах.	Тогтмол хэрэгжиж байна.	Төслийн талбайд байрлах ШТС-уудад галын аюулгүй байдлын санамж, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу байрлуулсан.

5		Гэнэтийн аюулаас сэргийлж ажилчдын байранд галын самбар, галын хор галын сарайг уурхайн бүх объектуудад зэргийг байрлуулах.	Тогтмол хэрэгжиж байна.	Нийт ШТС болон уурхайн объектуудад 7ш галын сарай, 4 ш галын мэдээллийн самбар, 73ш галын хорыг байрлуулсан.
6	Гэнэтийн осол аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ	Уурхайн нийт ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулж, уурхайн эрсдэлийн менежментийн дагуу ажиллах зааварчилгаа өгөх.	Тогтмол хэрэгжиж байна.	Уурхайн нийт ажилчдад шинэ ажилтны сургалт 207 ажилтанд, давтан сургалтыг 837 ажилтанд, ХАБЭА-н мэргэжлийн байгууллагаар сургалтыг 120 ажилтанд өгсөн. Өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, эрсдэлтэй ажлуудад ААДШ, Эрсдэлийн үнэлгээг хийж ажилладаг.
7		Аюул, осол эрсдэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулах, осол эрсдэлээс сэрэмжлүүлэх мэдээллийг өгч байх.	Тогтмол хэрэгжиж байна.	Уурхайд гэнэтийн осол аваар гарах, ОДТ болох тохиолдолд уурхайн диспетчер болон ХАБ-ын ажилтанд шуурхай мэдээлж, гарсан тохиолдлыг баримтжуулан сэрэмжлүүлэг мэдээг тогтмол өгч байна. 2024 онд нийт 25 удаа сэрэмжлүүлэг мэдээ гаргаж нийт ажилчдад мэдээлж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.
8		Аюул, ослын үед ажиллах аврах багийн сургалтыг Уул уурхайн аврах албатай зохион байгуулах	Тогтмол хэрэгжиж байна.	Уул Уурхайн аврах багаар 2024 онд хэрэгжүүлэн ажиллах “Ил уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г батлуулж, төлөвлөгөөний хүрээнд аюул ослын үед ажиллах сургалтыг зохион байгуулсан. Аврах багийг ээлж бүрт байгуулсан. Уул уурхайн аврах албатай хамтран галын сургалт, аврах үйл ажиллагааны сургалтыг уурхайн нийт ажилчдад хийсэн.

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад үүсч байгаа хог хаягдлыг хамгийн бага хэмжээнд байлгах, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зорьж ажиллаж байна.

- Төслийн үйл ажиллаганаас гарч буй ахуйн хог хаягдлын нийлүүлэх гэрээ Мандах сумын ЗДТГ-тай байгуулсан. Хог хаягдлын төлбөрт 1.8 сая төгрөгийн төлсөн.
- Аюултай хог хаягдал цуглуулах тээвэрлэх, устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид хаягдал шилжүүлэн өгөх гэрээг “ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.
- Төслийн хэмжээнд үүсч буй бүх төрлийн хог хаягдлын төрлийг тодорхойлж, тэдгээрийн ангилах, ялгах, цуглуулах, устгах ажил тогтмол хийгдэж байна
- Дахин ашиглагдах болон дахин боловсруулагдах хог хаягдлын үр дүнтэй зохицуулалт хийх зорилгоор зориулалтын сав байрлуулж тэмдэглэгээ хийж цуглуулж байна.
- Хог хаягдлыг багасгах үр дүнтэй аргуудыг хэрэгжүүлэх зорилгоор уурхайн талбайд ажиллаж байгаа бүх ажилтнуудад хог хаягдлын бохирдол, ангилал, дахин боловсруулалт, дахин ашиглалтын талаарх сургалтуудыг хийж байна.
- Засвар үйлчилгээний явцад гарч байгаа тосны шүүр болон бусад шатах, тослох материалаар бохирдсон хаягдлыг тусгайлан бэлтгэсэн сав, талбайд аюулгүй цуглуулах, түр хадгалах арга хэмжээг авч байна.
- Зориулалтын шатаах зуух ашиглан шатах боломжтой хог хаягдлыг байгаль орчинд хор хөнөөл багатайгаар устгаж байна.
- Төслийн талбайд ангилан ялгаж түр хадгалх хогийн цэгийг байгуулж, Мандах сумын төвлөрсөн хогийн цэгт энгийн хог хаягдлаа тээвэрлэн хяаж устгалд оруулж байна.
- Сумын хогийн цэгийн 06 сард техник гаргаж ландфилдэн булж, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан




Зураг№ 43. 2024.06-р сард сумын хогийн цэгийг техникээр ландфилдэн булшилж байгаа нь



Зураг№44. “Алаг Цав” төслийн ажилчдын хотхоны хог хаягдал ангилан ялгах цэг



Зураг№45. Хуванцар сав ангилан ялгалт



Зураг № 46. Ашигласан хаягдал тосыг шилжүүлэн өгч байгаа нь

Алаг Цав уурхайгаас Айл баян уурхайн уулзвар хүртэлх нүүрс тээврийн 100 км замын хог хаягдлын цэвэрлэгээг 2024 оны 07 сарын 07-09-ний хооронд 3 техник (ковш, хово, pick-up) 5хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн.

Нийт 80 тонн хог хаягдлыг цэвэрлэж орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт хаясан.



Уурхайд төвлөрсөн хог хаягдлыг ангилан ялгасан





Зураг№47. Тээврийн зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээ

Хүснэгт №16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Гүйцэтгэл
	1	2	3	4
Ахуйн хог хаягдал				
1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн талбай болон ажилчдын хотхонд стандартын шаардлага хангасан, ангилан ялгах тэмдэглэгээ бүхий хогийн сав байршуулах.	Тогмтол хэрэгжиж байна	Уурхайн талбайд ангилах ялгах хогийн түр цэг-3, Хогийн ангилан ялгах савыг бүх объектуудад, гадаа талбай, ажилчдын түр амрах хэсгүүдэд байрлуулсан. Нийт ангилан ялгах хогийн сав 35ш байрлуулж энгийн хог хаягдлын ангилан хаяж байна.
2		Хог хаягдлын түр хадгалах цэгийг тохижуулах, хашаажуулах	Тогмтол хэрэгжиж байна	Засварын газарт засвар үйлчилгээнээс гарч буй хог хаягдлыг ангилан ялгах түр цэгийг хийж, хашаажуулж тогтмол арчилгаа цэвэрлэгээг хийж байна. Кемпэд ахуйн хог хаягдлын ангилан ялгах түр цэгийг цементлэн хөрснөөс тусгаарлаж хашаа хамгаалалт хийсэн.
3		Мандах сумын ЗДТГ-тай Хог хаягдлын гэрээ хийж, хог хаягдлын гэрээ байгуулах	Тогмтол хэрэгжиж байна	Мандах Сумын Засаг даргатай 2024 оны 04 сарын 17-ний өдрийн №02 тоот гэрээг байгуулж, гэрээний дагуу хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэлт хийн ландфилдэн булшилж байна. 2024 онд 65 тонн хогийг сумын төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн. Гэрээний дагуу суманд хог хаягдлын төлбөр 1,8 сая төгрөгийг төлсөн.
4		Орон нутагтай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу ангилан ялгасан хог хаягдлыг холихгүйгээр ангилан ялгаж тээвэрлэх, устгах	Тогмтол хэрэгжиж байна	Суманд 65тн хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэн устгасан.

5		Төслийн талбай, нөлөөллийн бүсэд хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээг зохион байгуулах	Тогмтол хэрэгжиж байна	Төслийн талбайн орчим нөлөөллийн бүсэд улиралд 1 удаа хогны цэвэрлэгээ арга хэмжээг хийж байна.
6		Хог хаягдлын бүртгэл хөтлөх, тайлан мэдээг гаргах.	Тогмтол хэрэгжиж байна	Алаг Цав төслийн хогийн бүртгэлийг хөтөлж байна. Хүснэгт №15-аас үзнэ үү.
Аюултай хог хаягдал				
1	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээгээр хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлэх	Тогмтол хэрэгжиж байна	ОБ ОЙЛ ИНТАСТРАЛ ХХК-тай 2024 онд аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээг байгуулж, тээвэрлэлийг хийлгэсэн.
2		Аюултай хог хаягдлыг ангилж ялгах зориулалтын сав болон тэмдэг тэмдэглэгээтэйгээр түр цэгт хадгалах, цуглуулах, шилжүүлэх үйл ажиллагаа дээр хяналт тавьж, бүртгэл хөтлөх	Тогмтол хэрэгжиж байна	Кемп дээр ангилан ялгах хогийн түр цэг 1, засварын газарт ангилан ялгах аюултай хог хаягдлын түр цэг 1, нүүрсний агуулахад ангилан ялгах 1 цэгийг ашиглаж ангилан ялгалт хийгдэж байна. Мөн оффис, гал тогоо, бусад объектуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгах хогийн савууд байрлуулсан.
3		Аюултай хог хаягдал хадгалах түр цэгийн эмх цэгц, аюулгүй байдлыг хянах Ажлын байрны үзлэг /АБҮ/ тогтмол хийх	Тогмтол хэрэгжиж байна	АБҮ-ийг сар бүр хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажилладаг.
		Эмнэлгийн хог хаягдлыг сумын эмнэлэгтэй гэрээ байгуулан аюулгүй угсатх арга хэмжээг авах	Тогмтол хэрэгжиж байна	Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээг Мандах сумын Эрүүл мэндийн төвийн даргатай байгуулж 2023 оны 11 сарын 30-ний өдөр байгуулж, гэрээний дагуу уурхайн эмнэлгээс гарсан аюултай хог хаягдлыг устгаж байна. 2024 онд 17,8кг эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгуулсан.
4	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашигласан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах	Тогмтол хэрэгжиж байна	Засварын газарт засвар үйлчилгээнээс гарсан тосны шүүр, агаар шүүгч, тосны сав баглаа боодол, аккумуляторыг тусгай ангилан ялгах түр цэгт хадгалж гэрээний дагуу шилжүүлдэг.

11.1 Хог хаягдлын бүртгэл, тоо хэмжээ

Хог хаягдлын бүртгэлд үндэслэн 2023 онд төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгаж, аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулах, дахин боловсруулах үйлдвэрт өгч дахин боловсруулж байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй хог хаягдлын менежментийн хийж байна. Аюултай хог хаягдлыг ОБ ОЙЛ ИНДАСТРАЛ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан. Тайлангийн хугацаанд 15тн хаягдал тос, агаар шүүгч, тосны шүүр бусад хог хаягдал 5 тонн, хувцанцар савыг дахин боловсруулах үйлдвэрт 0,5 тн тус тус тушаасан.

Хүснэгт №17. Хог хаягдлын мэдээ, тайлан

Үзүүлэлт			Хэмжих нэгж	Хэмжээ	Устгалд оруулсан хаягдал	
Хог хаягдлын төвлөрсөн түр цэг /Ажилчдын амрах байр түр хадгалах цэг/			тоо	3		
Хог хаягдлын ангилан ялгах түр цэгийн нийт талбай			м²	70		
Засварын газрын төвлөрсөн түр цэг			тоо	1		
Зайлуулсан ахуйн хог хаягдал			тн	65	65	
Үүнээс	Энгийн		тн	29,2	20	
	Аюултай		тн	20	0.7	
	Хоолны хаягдал		тн	2.0	1.3	
	Дахин ашиглах		тн	15		
	Аюултай	Ашигласан тос		тн	15	1,0
		Аккумулятор		тн	1.0	-
		Тосны шүүр		тн	0.5	0,2
		Агаар шүүгч		тн	0.5	0,2
		Тостой арчих материал		тн	0,7	0,3
		Хаягдал төмөр		тн	1,0	-
		Тосны хувцанцар сав		тн	0,5	0,3
		Хуванцар сав		тн	0,5	0,5
		Хаягдал дугуй (том, жижи,дунд)		тн	9,5	-
Нийт зайлуулсан ахуйн болон хог хаягдлын хэмжээ			тн		79,7 тн	

Аймаг, нийслэл	Дорноговь	Улсын бүртгэлийн дугаар	
Сум, дүүрэг	Мандах сум	Регистерийн дугаар	
Аж ахуйн нэгжийн нэр	Их Түмэн Хүрд ХХК	Үйл ажиллагааны чиглэл буюу хог хаягдлын бүлэг	Уул уурхай

Хүснэгт №18. Алаг Цав төслийн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлын бүртгэл

№	Ангиллын код	Ангиллын код	Хуулийн нэршил	Ангиллын код	Хаягдлын нэр	Ангилал	Хэмжих нэгж	хэмжээ, тн	Хог хаягдлын талбайн байршил
1	16	16 02	15 02 01-д зааснаас бусад шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал	16 02 07*	CO2 шингээгч материал	Аюултай	тн	0	Дахин боловсруулах үйлдвэрт илгээнэ
2	16	16 06	Хартугалгатай батерей, аккумулятор	16 06 01*	Машины зай хураагуур	Аюултай	тн	0.0	Дахин боловсруулах үйлдвэрт илгээнэ
3	13	13 02	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад тос	13 02 05*	Техникийн хаягдал тос	Аюултай	тн	15	Дахин боловсруулах үйлдвэрт илгээнэ
4	16	16 01	Тосны шүүр	16 01 04*	Тосны шүүр	Аюултай	тн	0.5	Дахин боловсруулах үйлдвэрт
5	15	15 01	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	15 01 09*	Химийн бодисын хоосон сав /Төмөр будгийн сав/	Аюултай	тн	0	Дахин боловсруулах үйлдвэрт илгээнэ
6	15	15 01	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	15 01 09*	Химийн бодисын хоосон сав /Төмөр будгийн сав/	Аюултай	тн	0	Уурхайн дотоод хэрэгцээнд дахин ашиглана
7	15	15 01	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	15 01 09*	Химийн бодисын хоосон сав /Хуванцар 1 тн сав/	Аюултай	тн	0	Уурхайн дотоод хэрэгцээнд дахин ашиглана

№	Ангиллын код	Ангиллын код	Хуулийн нэршил	Ангиллын код	Хаягдлын нэр	Ангилал	Хэмжих нэгж	хэмжээ, тн	Хог хаягдлын талбайн байршил
8	15	15 01	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	15 01 09*	Химийн бодисын хоосон сав /Хуванцар канистер/	Аюултай	тн	0	Уурхайн дотоод хэрэгцээнд дахин ашиглана
9	16	16 05	Химийн бодисын хаягдал, даралттай саванд савласан хий	16 05 02	Шүршдэг будгийн сав болон баллон	Аюултай	тн	0.0001	Дахин боловсруулах үйлдвэрт илгээнэ
10	18	18 01	Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал	18 01 03	Эмнэлгийн хаягдал	Аюултай	тн	0,0017	Сумын эмнэлэгт илгээнэ
11	8	08 01	Органик уусгагч болон бусад хортой бодис агуулсан будаг, лакны хаягдал	08 01 01*	Будаг	Хяналттай	тн	0	Дахин боловсруулах талбай
12	8	08 03	Хортой бодис агуулсан хэвлэлийн хорны хаягдал	08 03 08*	Принтерийн хор	Хяналттай	тн	0	Аюулгүйгээр хадгалах
13	15	15 02	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал	15 02 01*	Тостой материал	Хяналттай	тн	0.7	Аюулгүйгээр хадгалах
14	15	15 01	Цаасан болон кардонон сав баглаа боодол	15 01 01	Цаасан хайрцаг	Энгийн	тн	0.1	Дахин боловсруулах талбай
15	18	18 01	Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаггүй халдваргүй хаягдал (боолт, шохойн боолт, даавуу)	8 01 04	Ариутгасан эмнэлгийн хаягдал	Энгийн	тн	0.001	Сумын эмнэлэгт илгээнэ
16	20	20 03	Холимог ахуйн хог хаягдал	20 03 01	Ахуйн хаягдал	Энгийн	тн	65	Сумын эмнэлэгт илгээнэ
17	10	10 13	Бетонын хаягдал ба бетонын лаг	10 13 10	Бетоны хаягдал	Энгийн	тн	0	Идэвхгүй хаягдлын талбай
18	20	20 01	Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал	20 01 99	Бүтээлэг	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай

№	Ангиллын код	Ангиллын код	Хуулийн нэршил	Ангиллын код	Хаягдлын нэр	Ангилал	Хэмжих нэгж	хэмжээ, тн	Хог хаягдлын талбайн байршил
19	10	10 01	Нүүрсний дэгдэмхий үнс	10 01 02*	Бүхэл үнс	Энгийн	тн	0	Идэвхгүй хаягдлын талбай
20	20	20 01	Хүнсний өөх тос	20 01 13	Гал тогооны тос	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
21	2	02 01	01 02 01, 01 02	02 01 01	Гал тогооны тостой ус	Энгийн	тн	5	Септик цэвэрлэх байгууламж
22	19	19 12	Хуванцар, резин	19 12 04	Гялгар уут	Энгийн	тн	0.002	Дахин боловсруулах талбай
23	16	16 01	Ашиглалтаас гарсан дугуй	16 01 01	Дунд дугуй	Энгийн	тн	9,0	Дахин боловсруулах талбай
24	16	16 01	Ашиглалтаас гарсан дугуй	16 01 01	Жижиг дугуй	Энгийн	тн	0.5	Дахин боловсруулах талбай
25	17	17 02	Мод	17 02 01	Мод	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
26	10	10 01	Зуухны доод үнс, шлак, зуухны тоос (10 01 04-д зааснаас бусад)	10 01 01	Нунтаг үнс	Энгийн	тн	5,0	Идэвхгүй хаягдлын талбай
27	19	19 08	Ахуйн бохир усны цэвэрлэгээний лаг (пресслэсэн лаг)	19 08 03	Нягтруулсан лаг	Энгийн	тн	0.0	Сайншанд Төвлөрсөн цэвэрлэх байгууламж
28	19	19 12	Хуванцар, резин	19 12 04	Резин	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
29	16	16 01	Тусгайлан заагдаагүй бусад эд анги	16 01 19	Резин хоолой	Энгийн	тн	0	
30	16	16 01	Төмөр	16 01 14	Сэндвич хавтан	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
31	16	16 01	Хар төмөрлөг	16 01 14	Төмөр	Энгийн	тн	0.5	Дахин боловсруулах талбай

№	Ангиллын код	Ангиллын код	Хуулийн нэршил	Ангиллын код	Хаягдлын нэр	Ангилал	Хэмжих нэгж	хэмжээ, тн	Хог хаягдлын талбайн байршил
32	20	20 01	Хуванцар	20 01 27	Хатуу хуванцар	Энгийн	тн	0.05	Дахин боловсруулах талбай
33	20	20 03	Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал	20 03 99	Хаягдал ус	Энгийн	тн	70,0	Ууршуулах цөөрөм
34	20	20 01	Биозадралд ордог хоол, хүнсний бүтээгдэхүүний хаягдал (гал тогоо)	20 01 03	Хоолны хаягдал	Энгийн	тн	1.5	Бордооны талбай
35	17	17 06	17 06 01, 17 06 02-д зааснаас бусад дулаалгын материал	17 06 03	Хөөсөнцөр	Энгийн	тн	0.05	Дахин боловсруулах талбай
36	19	19 12	Хуванцар, резин	19 12 04	Хуванцар усны сав	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
37	19	19 12	Хуванцар, резин	19 12 04	Хуванцар хоолой	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
38	16	16 02	Хаягдал тоног төхөөрөмжөөс ялгаж авсан 16 02 07-д зааснаас бусад бодис	16 02 08	Цахилгаан хэрэгсэл	Энгийн	тн	0.0	Дахин боловсруулах талбай
39	17	17 04	17 04 09-д зааснаас бусад кабель	17 04 10	Цахилгааны утас	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай
40	17	17 02	Шил	17 02 02	Шил	Энгийн	тн	0.002	
41	15	15 01	Нийлмэл материалтай сав баглаа боодол (өөр өөр материалаас бүрдсэн хэд хэдэн давхаргатай)	15 01 05	Шуудай	Энгийн	тн	0	Дахин боловсруулах талбай

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Их Түмэн Хүрд ХХК” нь уурхайн үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчныг хамгаалах, байгаль орчны сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, сөрөг нөлөөлөл гарсан тохиолдолд шуурхай арилгах, нийт ажилтнуудыг байгаль орчны мэдлэг олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулах, тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах бодлого, дүрэм журмыг гарган батлуулж, мөрдөн хэрэгжүүлж ажилласан.

Манай компани нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ:

- “Их Түмэн Хүрд ХХК”-ийн Алаг Цав нүүрсний уурхайн байгаль орчинд сөрөг нөлөөлөл, бохирдол үүсгэж байгаа эсэхэд мониторинг хяналтын ажлыг мэргэжлийн лаборатори, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх
- Байгаль орчны чанарын стандартыг шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд шаардлагатай залруулах ба сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх ба хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Уурхайд хөрс, ус агаар, ан амьтан, ургамалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй цэгүүдээс дээж авч “Байгаль орчин хэмжлзүйн төв лаборатори”, “Хан лаб” лаборатори, Инженер Геофизи ХХК-ийн “Хөрс судлалын лаборатори”-т хөрс, ус, агаарын шинжилгээг харьцуулан дүн шинжилгээ хийж уурхайн төслийн үе шатуудын явцад агаарын болон хөрс, усны шинж чанарт өөрчлөлт байгаа эсэхийг тодорхойлж, мэргэжлийн байгууллага, итгэмжлэгдсэн лабораториудын дүнд анализ хийж ажилласан.
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг “Эм Эс Си Эйч гранд нексус” ХХК -тай, амьтан ургамлын судалгаа, мониторингийн ажлыг мэргэжлийн судлаач, эрдэмтэд, багш нартай хамтран гүйцэтгэж үр дүнг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт №19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Гүйцэтгэл
1	Аэрозоль: PM2.5, PM10, нийт тоосонцор	Засварын шоп Уурын зуух ШТС	2	Агаарын хяналт шинжилгээг Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Эм Эс Си Эйч Гранд Нескус” ХХК-тай хамтран Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн мэргэжилтэн Ө.Сувд уурхайн мониторингийн цэгүүдэд хэмжилт хийж, дээж авч лабораторит шинжилгээ хийсэн.
	Агаар бохирдуулагчийн шинжилгээ (Нүүрстөрөгчийн исэл CO ₂ , хүхэрт устөрөгч SO ₂ , азотын давхар исэл NO ₂)		2	
	Цаг уур (агаарын хэм, салхины хурд, чиглэл, харьцангуй чийгшил, температур)	Уурхайн талбай, Нөлөөллийн бүс	2	Уурхайн талбай, Нөлөөллийн бүсэд Цаг агаарын үзүүлэлтүүдийгбагаж ашиглан хэмжилтийг тогтмол хийж байна. Цаг агаарын хүчтэй слахи, шуургатай, цастай бороотой үед уурхайн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч ажиллаж байна.
	Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)	Карьер, Засварын талбай, ажилчдын хотхон, технологийн зам	2	Карьер, Засварын талбай, ажилчдын хотхон, технологийн замд дуу шуугианыг DUSTRACK хэмжилтийн багаж ашиглан Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторын инженер Сувд хийсэн.
	Усны хими-физикийн шинжилгээ	Унд ахуйн худаг	4-4	2024 оны 05 сарын 31, 08 сарын 29-ний өдөр “Инженер Геодизи ХХК”-ийн хөрс судлалын лабораторит өгсөн. Шинжилгээгээр химийн бүрэлдэхүүнээр хлорын ангийн 1-р төрлийн чанарын хувьд нэн цэнгэг буюу маш бага эрдэсжилттэй зөөлөн ус тул ашиглаж байна.
		Шүүрүүлэхийн худаг	4-4	2024 оны 05 сарын 31, 08 сарын 29-ний өдөр “Инженер Геодизи ХХК”-ийн хөрс судлалын лабораторит өгсөн. Шинжилгээгээр химийн бүрэлдэхүүнээр натрийн бүлгийн 2-р төрлийн чанарын хувьд их эрдэсжилттэй маш хатуу ус гарсан тул зөвхөн зам талбайн усалгаа, модны усалгаанд ашиглаж байна.

		Шүүрлийн ус	4-4	Эхний 3 улиралд шүүрлийн усгүй байсан. 4-р улиралд уурхайн карьерынтүвшнээс шүүрлийн ус 2024 оны 10 сард гарч эхэлсэн ба шинжилгээг 1 удаа хийлгэсэн.
		Малчны худаг	4-4	2024 оны 05 сарын 31, 08 сарын 29-ний өдөр “Инженер Геофизи ХХК”-ийн хөрс судлалын лабораторит өгсөн. Шинжилгээгээр химийн бүрэлдэхүүнээр натрийн бүлгийн 2-р төрлийн чанарын хувьд цэнгэг, их эрдэсжилттэй маш хатуу ус гарсан тул зөвхөн зам талбайн усалгаа, модны усалгаанд ашиглаж байна.
	Эрүүл ахуй, бичил амь судлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	Ундны усны худаг	2	2024 оны 08 сарын 29-ний өдөр “Инженер Геофизи ХХК”-ийн хөрс судлалын лабораторит өгсөн. Шинжилгээгээр стандарт давсан үзүүлэлт илрээгүй.
	Усны эрүүл ахуйн үзүүлэлт, бохирдлын судалгаа (бохир уснаас дээж авах)	Бохир цэвэрлэх байгууламж	2-2	2024 оны 05 сарын 31-ний өдөр СХЗГ-ын Хүсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн хими, хор судлалын лаобратори-т цэвэрлэх байгууламжийн танкнаас дээж авч шинжилгээнд өгсөн. Шинжилгээгээр Хлор 28,2 мг/л, Нитрат 2,2 мг/л тус тус гарсан. Бусад үзүүлэлт хэвийн стандарт давсан үзүүлэлт гараагүй.
2	Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Уурхай	2	2024 оны 05 сарын 31, 2024 оны 10 сарын 15-ний өдөр шинжилгээг Инженери Геофизи ХХК-ийн хөрс судлалын лабораторит өгсөн. Стандарт давсан үзүүлэлт гараагүй.
		Засварын шоп	2	
		Ажилчдын хотхон	2	
3	Хөрсний чанар, нянгийн шинжилгээ	Ажилчдын хотхон	2	
	Хөрсний чанар, хүнд металлын шинжилгээ	ШТС, засварын талбай	2	Засварын газар, ШТС, Хогийн цэг, кемп, уурхай (паркын талбай), нүүрсний агуулах, хаягдлын овоолго гэсэн 7 цэгээс, 2024 оны 05 сарын 31 өдөр 10 сарын 15-ний өдөр шинжилгээг Инженери Геофизи ХХК-ийн хөрс судлалын лабораторит өгсөн. Стандар давсан үзүүлэлт гараагүй.
	Урт хугацаанд хадгалагдах шимт хөрсний физик, хими, үржил шимт чанарын үзүүлэлтүүд	Уурхайн талбайд байрлах урт хугацааны шимт хөрсний 2 овоолгоос	2	2024 оны 10 сарын 15, 11 сарын ... өдөр шимт хөрсний 2 овоолгоос дээж авч шинжилгээнд өгсөн. Ялзамгийн хувьд 0,16% маш бага ялзмагтай гарсан.

4	Ургамлын судалгаа	Төслийн талбайн хэмжээнд	1	Ургамлын судалгааг Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Эм Эс Си Эйч Гранд Нексус” ХХК-тай гэрээ байгуулж, Ботаникийн хүрээлэнгийн судлаач Сэмжид, Э.Энхжаргал нар хийж гүйцэтгэсэн. Байгаль орчны мониторингийн тайлангаас амьтны аймаг хэсгээс үзнэ үү.
5	Ан амьтны ажиглалт судалгааг төслийн талбай, нөлөөллийн бүсэд хийх	Нөлөөллийн бүсэд	1	Ан амьтны судалгааг Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Эм Эс Си Эйч Гранд Нексус” ХХК-тай гэрээ байгуулж, амьтан судлаач багш Э.Мөнхжаргалаар судалгааг хийлгэсэн. Байгаль орчны мониторингийн тайлангаас амьтны аймаг хэсгээс үзнэ үү.
	Уурхайн ойр орчимд ан амьтдын осол эндэгдэл, ажиглалтын бүртгэл хийх	Лицензийн талбайд		Уурхайн орчимд ажиглалт судалгааг тогтмол хийж байгаа ба лицензийн талбайд хөхтөн амьтан үхэж эндсэн тохиолдол гараагүй.

12.1.АЛАГ ЦАВ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

MV-021559 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаартай “Түмэн айл” чулуун нүүрсний орд ашиглах Алаг Цав төслийн нүүрсний уурхайд 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ болон 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эм Эс Си Эйч гранд нексус ХХК хийж гүйцэтгэлээ.


Их Түмэн Хүрд ХХК”-ийн Алаг Цав нүүрсний уурхайн байгаль орчинд сөрөг нөлөөлөл, бохирдол үүсгэж байгаа эсэхэд мониторинг хяналтын ажлыг мэргэжлийн лаборатори, мэргэжлийн судлаач, мэргэжилтэн нартай хамтран ажилласан. Алаг Цав төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- Уурхайн үйл ажиллагаанаас хөрс, усанд нөлөөлөл үзүүлж болзошгүй цэгүүдээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ өгөх, шинжилгээний үр дүнд анализ хийх
- Уурхайн үйл ажиллагаанаас агаарт үзүүлж буй сөрөг нөлөөлөл стандартаас давсан эсэхэд багажаар хэмжилт хийх, дээж авах (тоосжилт, дуу шуугиан,)
- Лицензийн талбай, нөлөөллийн бүсэд амьтан, ургамлын мониторинг судалгаа хийх
- Анализ дүн шинжилгээнд үндэслэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй нөлөөллийг 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Орчны хяналт шинжилгээ хийж гүйцэтгэсэн баг

№	Судлаачийн нэр	Албан тушаал	Мэргэжил, ажил
1	Ч.Ганзориг	Захирал, Багийн ахлагч	Экологич, Байгалийн ШУ-ны магистр
2	Т.Сэмжид	Ургамал судлаач,	Ургамлын физиологич, Биологийн ШУ-ы магистр
3	Э.Мөнхжаргал	Амьтан судлаач,	Экологич, Биологийн ШУ-ы магистр
4	Э.Энхжаргал	Ургамал судлаач	Экологич, Биологийн шинжлэх ухааны магист
4	Д.Сувд	БОХЗТ лаборатори Агаарын техникч	Цаг уурын техникч
Алаг Цав уурхайгаас судалгаанд хамтран оролцсон ажилтнууд			
	Б.Баянсан	Кемп менежер	
5	Буянтогтох	ХАБ-ийн мэргэжилтэн	Аялал жуулчлалын мэргэжилтэн


Хээрийн судалгаанд явсан баг бүрэлдэхүүн



12.1.1. Алаг Цав төслийн мониторингийн цэг, байршил

Хүснэгт № 20 Дээж авсан цэгийн байршил

№	Байгалийн бүрэлдэхүүн	Дээж авсан цэгийн байршил	Нийт дээж	Шинжилгээ хийлгэсэн лаборатори
1	Хөрсний хяналт шинжилгээ	Ажилчдын хотхон, хотхоны хог хаягдлын түр цэг, засварын газар, ШТС, Уурхайн машин паркын талбай, Шимт хөрсний овоолго, Нүүрсний агуулах, Хаягдлын овоолго	8 дээж 3 удаа	Хөрс судлалын лаборатори, “Инженер геодези” ХХК
2	Агаарын хяналт шинжилгээ	Ажилчдын хотхон, засварын газар, ил уурхай, гадаад овоолго, нөлөөллийн бүс, технологийн заи	6 дээж 2 удаа	ЦУОШГ-ын “Байгаль орчин, хэмжилзүйн төв лаборатори”
3	Усны хяналт шинжилгээ	Ажилчдын хотхоны худаг, уурхайн худаг, малчдын худаг, шүүрлийн ус, бохир ус	5 дээж 4 удаа	“Инженер геодези” ХХК Хөрс судлалын лаборатори
4	Ургамлын мониторинг	Уурхайн лицензийн талбай, нөлөөллийн бүс	4 цэгт 1 удаа	Эм Эс Ст Эйч Гранд нексус ХХК-тэй гэрээ байгуулж хийлгэсэн
5	Амьтны мониторинг	Уурхайн лицензийн талбай, нөлөөллийн бүсэд	Нөлөөллийн бүс 1 удаа	Эм Эс Ст Эйч Гранд нексус ХХК-тэй гэрээ байгуулж хийлгэсэн



Зураг №48. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн цэг

12.2.АГААРЫН ЧАНАР

Агаарын бохирдлыг тодорхойлогч бодисуудын товч тодорхойлолт

- **Нийт тоосонцор (*Suspended particulate matter (SPM), total suspended TSP*):** Агаарт дэгдэх төлөвт тоос шороо, утаа униар, усны уур тодорхой хугацааны туршид оршин байх бөгөөд эдгээр эгэл хэсгүүд алсын барааг муутгадаг. Аэрозол амьсгалаар дамжин уушигний нүх сүвээр орж уушгийг гэмтээх, амьсгалах процесст нөлөөлдөг.
- **PM 2.5 (*Particulate Matter 2.5*):** 2.5 микрометрээс бага диаметртэй тоосонцор юм. Үүнийг уушгинд нэвтэрдэг тоосонцор гэж нэрлэдэг. Энэ тоосонцор их хэмжээний хорт бодис агуулахаас гадна агаарт урт хугацааны туршид тогтож, алс зайд нүүдэллэдэг учраас амьсгалын замаар дамжин уушгины агаарын солилцоонд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ бронхит, астма үүсгэхээс гадна зүрх судас болон цусны эргэлтийн тогтолцооны өвчний гол шалтгаан болдог.
- **PM 10 (*Particulate Matter 10*):** 10 микрометрээс бага диаметртэй тоосонцрыг хэлнэ. Ийм хэмжээтэй тоосонцрыг амьсгалыг дагаж ордог тоосонцор гэж нэрлэдэг байна. Энэ тоосонцор агаарт урт хугацааны туршид дэгдэмхий байдлаар орших чадвартай бөгөөд хүний биед амьсгалын замаар нэвтэрч зарим төрлийн өвчнийг үүсгэнэ.
- **Хүхэрлэг хий (*Sulphur dioxide, SO2*):** Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхитэй ордог хий. Нүүрс, газрын тосны шаталтаас үүсдэг. Голдуу нүүрс хэрэглэдэг дулааны станцуудаас хаягдана. Мөн цаас боловсруулах болон төмөр хайлуулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн процессийн үед ялгардаг байна. Энэ хий хүчиллэг тунадас, утааны гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд уушигны үрэвслийг бий болгодог.
- **Нүүрстөрөгчийн дутуу исэл (*Carbon monoxide, CO*):** Өнгөгүй, үнэргүй энэ хий бензин, дизель болон нүүрстөрөгч агуулсан түлшний дутуу шаталтаас үүсдэг. Түүнчлэн байгалийн болон байгалийн бус (тамхи мэтийн) бүтээгдэхүүний шаталтаас үүсдэг. Энэ хийн хольц хүний цусанд нэвтрэх хүчилтөрөгчийн хэмжээг багасгаснаар рефлексийг сулруулж, унтаа байдалд оруулдаг.
- **Азотын исэл (*Nitrogen oxide, NOx*):** Азотын исэл утаа униар болон хүчиллэг тунадасыг бий болгодог. Энэ нь бензин, дизель, нүүрс мэтийн түлшний шаталтаас үүсдэг. Ялангуяа өвлийн улиралд хүүхдийн амьсгалын замын өвчний дэгдэлтийн гол шалтгаан болно.

Уурхай орчмын агаарын чанар

Тус хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын тоосжилт, бохирдуулагч хорт хийн хэмжилтийг ажилчдын хотхон, засварын газар, ил уурхай, гадаад овоолго зэрэг 5 цэгт хэмжилт хийлээ.

Хэмжилтийг **DUST TRACK** багажаар хийж шинжилгээг Цаг уур, орчны шинжилгээний газрын, Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид хийлгэв. /Шинжилгээний хариуг хавсаргав/

Хүснэгт №21. Агаарын хэмжилт хийсэн газрын координат цэг

№	Дээж авсан газар	Өргөрөг			Уртраг		
1	Ажилчдын хотхон	44	9	10.88	108	14	49.23
2	Засварын шоп	44	9	0.33	108	14	45.15
3	Ил уурхай	44	8	56.36	108	16	16.95
4	Гадаад овоолго	44	8	48.56	108	15	44.5
5	Технологийн зам	44	8	48.15	108	15	54.00
6	Нөлөөллийн бүс	44	7	54.18	108	16	41.38



Зураг №49. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж буй байдал

Хүснэгт №22. Агаарын чанарын шинжилгээний үр дүн

Дээж авсан цэг	Хүхэрлэг хий (мг/м3)	MNS 4585:2016	Азотын давхар исэл (мг/м3)	MNS 4585:2016	Нийт тоос (TSP)	MNS 4585:2016	Дуу чимээ (ДБА)	MNS 4585:2016
Ажилчдын хотхон	0.021	0.045	0.052	0.200	0.120	0.500	55	60
Засварын газар	0.014	0.045	0.080	0.200	0.136	0.500	60	60
Нүүрсний овоолго	0.013	0.045	0.049	0.200	0.380	0.500	84	60
ШТС	0.016	0.045	0.043	0.200	0.260	0.500	65	60
Технологийн зам	0.021	0.045	0.049	0.200	0.200	0.500	65	60
Нөлөөллийн бүс	0.017	0.045	0.043	0.200	0.314	0.500	65	60

График № 2. Хүхэрлэг хийн үзүүлэлт







График № 5. Дуу чимээ



Хэмжилтийн үр дүнгээс харахад судалгааны цэгүүд дээр Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, нийт тоосны хэмжээ Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 үзүүлэлт дээр давсан утга байхгүй буюу агаарын бохирдолгүй байна.

Дуу чимээ нүүрсний овоолгын орчинд стандарт үзүүлэлтээс их байна. Иймд нүүрс баяжуулах үйлдвэрийн орчимд ажиллаж байгаа ажилчдын эрүүл мэнд аюулгүй ажиллагааг хангасан хөдөлмөр хамгаалах хэрэгслэлээр тогтмол хангах, жил бүр тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийх шаардлагатай.

12.3. Усны хяналт шинжилгээ

“Их Түмэн Хүрд” ХХК нь унд ахуй, уурхайн тоосжилтыг дарах усалгааны зориулалтаар 1 гүний худаг ашигладаг. Мөн төслийн талбайд унд ахуйн зориулалттай 1 худаг, малчдын мал услах зориулалттай 1 худаг нийт 3 худагтай.

Малчны зориулалттай худаг нь одоогоор ашиглагдахгүй байна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 3 худгаас дээжлэлт хийж усны хими, физик шинж чанарыг тодорхойлов.

Хүснэгт № 23. Гүний худгуудын байршил

№	Дээж авсан газар	Өргөрөг			Уртлаг		
1	Уурхайн худаг	44	8	31.00	108	16	1.41
2	Ажилчдын хотхон	44	9	11.92	108	14	48.34
3	Малчдын худаг	44	8	54.00	108	14	33.89
4	Шүүрлийн ус	44	8	55.45	108	16	20.39
5	Бохир ус	44	9	8.73	108	14	44.86

12.3.1. Судалгааны аргазүй

Усан орчны ОХШХ-ийн мониторингийн цэгүүдээс усны дээжлэлт авсан болно.

- Дээжлэлтийг авахдаа: **MNS ISO5667-6-2001**
- Ерөнхий химийн үзүүлэлтийг “Инженер геодези ХХК-ийн усны шинжилгээний лаборатори, Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторит шинжилгээ хийв.
- Ерөнхий химийн үзүүлэлтийг “MNS 0900:2018” Монгол улсын ундны усны стандартай харьцуулж дүгнэлт өглөө.

12.3.2. Судалгааны үр дүн:

1. **Гүний худаг 1-/Кемпийн худаг/:** Тус худгийн ус нь Инженер геодези ХХК-ийн Хөрс судлалын итгэмлэгдсэн лабораторит 2024 оны 10 сарын 14-ний өдөр өгсөн шинжилгээний дүнгээр усан орчины хувьд **сул шүлтлэг, усны хатуулаг маш хатуу, өнгөгүй, үнэргүй, булингаргүй, тунгалаг, хуурай үлдэгдэл 1756,0 мг/л, исэлдэх чанар 0,96 мг/л** үзүүлэлттэй, 2024 оны 08 сарын 29-ний өдрийн шинжилгээний дүнгээр **чанарын хувьд их эрдэсжилттэй, хатуу, өнгөгүй, үнэргүй, булингаргүй, тунгалаг, хуурай үлдэгдэл 1732,0 мг/л, исэлдэх чанар 0,80 мг/л** үзүүлэлттэй гарсан байна.




График № 6. Гол ионуудын агууламж (Стифф)

Шинжилгээний дүнгээс үзвэл химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд их эрдэсжилттэй, маш хатуу ус байна.

Шинжилсэн химийн үзүүлэлтүүдээс ерөнхий хатуулаг, сульфат ион, хуурай үлдэгдэлийн хэмжээ “Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй боловч өндөр агууламжтай байна. Ундны усанд хэрэглэхэд тохиромж муу бөгөөд заавал шүүж, хатуулгийг бууруулж хэрэглэх шаардлагатай. Диаграммаас харахад катионаас натри кали ион, анионаас гидрокарбонат ион зонхилсон байна.

2. Худаг 2-Шүүрүүлэлтийн худаг): Энэ худаг нь ашиглалтын хувьд замын тоосжилт дарах усалгаа, ногоон байгууламжийн усалгаа, мал амьтны усалагаа бусад унд ахуйн хэрэглээнээс бусд хэрэглээнд ашиглаж байна.

2024 оны 08 сарын 29-ний шинжилгээний үр дүнгээр:

- Шинжилгээний дүнгээс үзвэл химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд их эрдэсжилттэй, маш хатуу ус
- усан орчины хувьд сул сул шүтлэг, усны хатуулагтай, өнгөгүй, үнэргүй, булингаргүй, тунгалаг, хуурай үлдэгдэл 2318,0 мг/л, исэлдэх чанар 1,44 мг/л үзүүлэлттэй гарсан байна.

2024 оны 08 сарын 29-ний шинжилгээний үр дүнгээр:

- Шинжилгээний дүнгээс үзвэл химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд их эрдэсжилттэй, маш хатуу ус

усан орчины хувьд сул сул шүлтлэг, усны хатуулагтай, өнгөгүй, үнэргүй, булингаргүй, тунгалаг, хуурай үлдэгдэл 2310,0 мг/л, исэлдэх чанар 15,84 мг/л үзүүлэлттэй гарсан байна

Шинжилсэн химийн үзүүлэлтүүдээс ерөнхий хатуулаг, сульфат ион, хуурай үлдэгдэлийн хэмжээ “Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй боловч өндөр агууламжтай байна. Ундны усанд хэрэглэх тохиолдолд заавал шүүж, хатуулгийг бууруулж хэрэглэх шаардлагатай.

3. Гүний худаг 3-/Малчны худаг/: Энэхүү худаг нь одоогоор ашиглалт байхгүй.

2024 оны 05 сарын 31-ний шинжилгээний үр дүнгээр:

- Шинжилгээний дүнгээс үзвэл химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг их эрдэсжилттэй, маш хатуу устай
- Тус худгийн ус нь өнгөгүй, үнэргүй, булингаргүй, тунгалаг, хуурай үлдэгдэл 3380.0 мг/л, исэлдэх чанар 1.28 мг/л үзүүлэлттэй гарсан байна.

Хүснэгт № 24. Шинжилгээний нэгдсэн дүн (ундны ус)

дд	Сорилтын үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ (MNS 0900:2018)	ДЭМБ	Гүний худаг 1	Гүний худаг 2	Гүний худаг 3	Цэвэршүүлсэн ус	Сорилт гүйцэтгэсэн стандартын дугаар
1	pH	6.5-8.5	<8	7.84	8.49	8.24	7.84	MNS ISO 10523:2001
2	Ерөнхий хатуулаг (мг-экв/л)	< 7.0	-	7.60	7.40	20.4	0.30	MNS (ISO) 6059:2005
3	Натри+Кали, мг/л	200	-	518.54	676.96	986.50	25.74	MNS 1097:1970
4	Аммонийн ион	0.5	-	0.10	0.40	0.01	0,0	MNS 1097:1970
5	Кальци, мг/л	100	-	54.11	140.28	164.33	4,01	MNS 1097:1970
6		< 30.0	-	59.58	127.68	148.35	1,22	MNS 1097:1970
7	Карбонат, мг/л	-		0.0	0.0	15.4	0,0	MNS ISO 9963-1:2005
8	Хлорид, мг/л	350.0	250	354.50	709.0	677.10	21.27	MNS 9297:2005
9	Гидрокарбонат, мг/л	-	-	793.26	549.18	1037.34	48.82	MNS ISO 9963-1:2005
10	Нитрит, мг/л	< 1.000	50	0.00	0.50	0.0	0.0	MNS 4431.2005
11	Нитрат, мг/л			0.02	2.0	1.72	0.69	MNS 4431.2005

дд	Сорилтын үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ (MNS 0900:2018)	ДЭМБ	Гүний худаг 1	Гүний худаг 2	Гүний худаг 3	Цэвэршүүлсэн ус	Сорилт гүйцэтгэсэн стандартын дугаар
12	Төмөр, мг/л	0.3	-	0.3	0.0	0.3	0.0	MNS 4430:2005
13	Сульфат, мг/л	500	500	341.10	852.01	1307.3	0.42	MNS 6271:2011
14	Хуурай үлдэгдэл, мг/л	< 1000	-	2918.0	2886.0	888.0	80.0	MNS 4423:1997

Шинжилгээний дүнгээс үзэхэд: **Натри+Кали, мг/л** -Худаг 1, Худаг2, Худаг 3 стандартаас давсан, **Сульфат, Кальци, мг/л** -Худаг 2, Худаг 3-т стандартаас давсан, **Гидрокарбонат, мг/л** Худаг 1, Худаг2, Худаг 3 стандартаас давсан, **Хуурай үлдэгдэл мг/л** Худаг 1, Худаг2, Худаг 3, стандартаас давсан үзүүлэлттэй байна.

Ундны усны зориулалтаар ашиглаж байгаа усыг шүүж цэвэршүүлэх төхөөрөмжөөс авсан усны дээж нь бүх үзүүлэлтээрээ стандартын шаардлагыг хангаж байна.

Бохир усны шинжилгээний үр дүн:

Дээжийн дугаар	Шинжилсэн үзүүлэлтийн нэр	Шинжилгээний аргын стандарт	Шаардлага	Шинжилгээний дүн
	Аммони	MNS ISO 7150-2006	15.0 мг/л ихгүй	1.2 мг/л
	БХХ хүчилтөрөгч	MNS ISO 5815-1-2015	400,0 мгО/л ихгүй	355,9 мгО/л
	Нийт хлор	MNS ISO 9797-2005	-	28,2 мг/л
	Нитрат	MNS ISO 7890-3-2001	-	2,2 мг/л
	рН	MNS ISO 10523-2001	6,0-9,0	7,5
	Умбуур бодис	MNS ISO 11923-2001	400,0 мг/л ихгүй	106,0 мг/л
	Нийт шүлтлэг	MNS ISO 9963-1-2005	-	15,5 ммоль/л
	Холимог шүлтлэг	MNS ISO 9963-1-2005	-	0,0ммоль/л

Уурхайн ажилчдын хотхоны бохирын септик танкнаас 2024 оны 06 сарын 05-ний өдөр дээж авч СХЗГ-ын Аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Хими хор судлалын лабораторит шинжилгээ өгсөн үр дүнгээс үзэхэд стандартаас давсан үзүүлэлт гараагүй байна. (Хавсралт шинжилгээний дүнгээс үзнэ үү)

Цаашид бохир усны цэвэрлэгээг сайжруулж саарал ус болгон замын усалгаа, мод усалгаанд дахин ашиглалтыг нэмэгдүүлж, говийн усны нөөцийн хэмнэхэд анхаарах шаардлагатай.

Дүгнэлт:

Газрын доорх ус нь нийтлэгээрээ гидрокарбонат анги, 2-р төрлийн, хатуу ус бөгөөд усны төрлийн хувьд $\text{Ca}(\text{HCO}_3)_2$ найрлага бүхий ус давамгайлж байна. Төслийн талбай орчимд хур тунадас бага, газрын доорх усны эргэлт удаан явагддаг тул, солилцоонд орох чадвар бага, ижил төрлийн найрлагатай боловч зарим тохиолдолд шинж чанар болон тэжээгдлийн нөхцөлөөс хамаарч өөрчлөгдөх магадлалтай байдаг.

Гүний худгуудын хувьд эрдэсжилт ихтэй, хатуулаг өндөр, унд ахуйд шууд хэрэглэхэд тохиромжгүй гарсан байна.

Худгийн усны чанарт тухайн орчны хөрсөн бүрхэвчийн шинж чанар, уур амьсгал, байгалийн бүс бүслүүр нөлөөлсөн байх магадлалтай юм.

Тус малчны худгийн усыг унд ахуйд ашиглахдаа заавал шүүлтүүрээр шүүх, эсвэл хатуулаг болон эрдэсжилтийг багасган хэрэглэх шаардлагатай.

Уурхайн ажилчдын хотхонд унд ахуйд ашиглаж байгаа худгийн усыг ус цэвэршүүлэгч шүүлтүүр тавьж ашиглаж байгаа нь ажилчдыг хатуулаг, эрдэсжилт ихтэй ус ашиглахаас сэргийлж хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлтийг хангасан үр дүнтэй ажил байна.

12.4.ХӨРСӨН БҮРХЭВЧ**12.4.1. Судалгааны аргазүй**

Дээж авах цэг сонгосон загвар: Судалгааны зорилго, хамрах хүрээ зэргээс шалтгаалан хөрсний дээж авах цэг сонгох аргазүй буюу загвар өөр өөр байдаг (трансектийн дагуу авах, торлол үүсгэж цэг сонгох, санамсаргүй аргаар түүвэрлэж авах г.м).

MV-021559 тоот талбайн хөрс орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт БОМТ-ний дагуу ажилчдын хотхон, хотхоны хатуу хог хаягдлын цэг, засварын шоп, ШТС, уурхайн машин паркын талбай зэрэг уул уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн талбайг сонгож санамсаргүй аргаар түүвэрлэж хөрсний дээж авсан.

12.4.2. Хөрсний хяналт шинжилгээ, мониторинг

Алаг Цав төслийн хөрсний хөрсний хяналт шинжилгээг 2024 оны 5 дугаар сар болон 9, 10 дугаар саруудад хийж гүйцэтгэсэн ба нийт 8 цэгээс 0-10 см гүнд өнгөн хөрсний дээж авсан.

Сонгосон цэгээс хөрсний дээж авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталлаа. Хөрсний хими, физик шинж чанар болон хүнд металлын бохирдлын шинжилгээг “Инженер геодези”ХХК-ийн хөрс судлалын лаборатори, Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлэв.

Хүснэгт № 25. Хөрсний мониторингийн координат цэг

ОХШХ-ийн мониторингийн цэг	Өргөрөг			Уртраг		
Кемп	44	9	10. 61	108	14	50.44
Хогийн цэг	44	9	8.1	108	14	55.87
Засварын шоп	44	9	0.86	108	14	42.65
ШТС	44	9	2.87	108	15	8.30
Уурхайн машин паркын талбай	44	8	49.15	108	16	1.25
Нүүрсний агуулах	44	8	16.31	108	15	54.87
Хаягдлын овоолго	44	8	38.68	108	15	33.63
Шимтс хөрсний овоолго	44	8	52.68	108	15	57.00

12.4.3. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт, морфологи бичиглэл

Хөрсний судалгааны цэг-1

Газрын гадаргын төлөв байдал:



Зураг № 50. Хөрсний судалгааны цэг-1, Ажилчдын хотхон

Байршил: Лицензийн талбайн баруун хойно

Чулууны бүрхэц: 20%

Хөрсний эвдрэл: Антропоген


Зонхилох ургамал: Ургамлан бүрхэвч талхлагдсан

Хөрсний нэр: Говийн элсэрхэг бор хөрс

Үе давхарга: Хөрс хүн техникийн нөлөөгөөр элэгдэлд орсон, өнгөн үе давхаргын үржил шимт нөөц багассан, бор өнгөтэй, жижиг чулуутай, ургамлын үндэсгүй, хуурай, элсэнцэр бүрэлдэхүүнтэй, нягтавтарт.

Хөрсний судалгааны цэг-2

Газрын гадаргын төлөв байдал:



Зураг № 51. Хөрсний судалгааны цэг-2, Хатуу хог хаягдлын цэг

Байршил: Лицензийн талбайн баруун хойно, ажилчдын хотхоны зүүн урд

Чулууны бүрхэц: 40%

Хөрсний эвдрэл: Антропоген, техноген

Зонхилох ургамал: Ургамлан бүрхэвч талхлагдсан

Хөрсний нэр: Говийн элсэрхэг бор хөрс

Үе давхарга: Хөрс хүн техникийн нөлөөгөөр элэгдэлд орсон, өнгөн үе давхаргын үржил шимт нөөц багассан, бор өнгөтэй, жижиг чулуутай, ургамлын үндэс мэр сэр, хуурай, элсэнцэр бүрэлдэхүүнтэй, нягт.

Хөрсний судалгааны цэг-3

Газрын гадаргын төлөв байдал:



Зураг № 52. Хөрсний судалгааны цэг-3, Засварын газар

Байршил: Лицензийн талбайн баруун хойно, ажилчдын хотхоны урд

Хөрсний эвдрэл: Хөрс онцгой их эвдрэлд орсон. Хөрсний үржил шимт өнгөн давхарга талхлагдаж, ургамлан бүрхэвч устсан, чулууны агууламж нэмэгдсэн буюу бүрхэц 80%

Хөрсний нэр: Эвдрэлд орсон хөрс

Үе давхарга: Хөрс техникийн нөлөөгөөр онцгой их элэгдэлд орсон, хөрсний үржил шимт өнгөн үе давхарга, бүтэц алдагдсан, цайвар бор өнгөтэй, чулуутай, ургамлын үндэсгүй, хуурай, элсэнцэр бүрэлдэхүүнтэй, нягтавттар.

Хөрсний судалгааны цэг-4

Газрын гадаргын төлөв байдал:



Зураг № 53. Хөрсний судалгааны цэг-4, Шатахуун түгээх станц

Байршил: Уурхайн ШТС-ын талбай

Хөрсний эвдрэл: Үржил шимт хөрсийг хуулан авч газрыг тэгшилж эвдрэлд орсон. Хөрсний үржил шимт өнгөн давхарга талхлагдаж, ургамлан бүрхэвч устсан, чулууны агууламж нэмэгдсэн буюу бүрхэц 0%

Хөрсний нэр: Эвдрэлд орсон хөрс

Үе давхарга: Хөрс машин антропогений нөлөөгөөр орсон, өнгөн үе давхаргын үржил шимт нөөц багассаж чулуун хучаас үүссэн, цайвар бор өнгөтэй, чулуутай, ургамлын үндэсгүй, хуурай, элсэнцэр бүрэлдэхүүнтэй, нягт.

Хөрсний судалгааны цэг-5

Газрын гадаргын төлөв байдал:



Зураг № 54. Хөрсний судалгааны цэг-5, Уурхайн машин паркын талбай

Байршил: Лицензийн талбайн төв хэсэгт, ил уурхайн баруун талд

Хөрсний эвдрэл: Хөрс онцгой их эвдрэлд орсон. Хөрсний морфологи тогтоц, бүтэц алдагдаж, ялзмагийн агууламж буурсан, ургамлан бүрхэвч устсан.

Чулууны бүрхэц: 30%

Хөрсний нэр: Эвдрэлд орсон хөрс

Үе давхарга: Цайвар бор өнгөтэй, жижиг чулуутай, ургамлын үндэсгүй, хуурай, хөнгөн шавранцанр бүрэлдэхүүнтэй, маш нягт.

12.4.4. Хөрсний хими, физик шинж чанар

Хөрсний хими болон физик шинжийн задлан шинжилгээгээр химийн үндсэн үзүүлэлтүүд болох хөрсний ялзмагийн хэмжээ, урвалын орчин /рН/, хөрсний давсжилт, цахилгаан дамжуулах чадвар, хөрсөн дэх хөдөлгөөнт элементүүд болох фосфор, кали, солилцох суурь элементүүд кальци, магни зэргийг тодорхойлж хүснэгтээр үзүүлсэний зэрэгцээ механик бүрэлдэхүүнийг ширхэгийн хэмжээний ангиллаар буюу Гидрометрийн аргаар тодорхойлуулж дүнг тус тус үзүүлсэн болно.

БОМТөлөвлөгөөний дагуу 05 сарын 31, 9-р сар, 10 дугаар 14-ний өдөр хөрсний дээж авч Инженер Геодези ХХК-ийн Хөрс судлалын лаборатори, Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториудад шинжилгээг хийлгэсэн. Хөрсний хими физик шинж чанарын лабораторийн шинжилгээний дүнг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт № 26. Хөрсний хими физик шинж чанар, 2024 оны 5 дугаар сар

Дээжний дугаар	Гүн, см	рН	ЦДЧ dS/m	Ялзмаг %	CaCO ₃ %	Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
Кемп	0-10 см	8.93	0.124	0.42	0.68	2.1	23
Хогийн цэг	0-10 см	9.21	0.124	0.24	0.82	2.2	29
Засварын газар	0-10 см	9.31	0.390	0.43	1.65	1.7	11
ШТС	0-10 см	9.70	0.109	0.27	0.66	1.4	11
Уурхайн машин паркын талбай	0-10 см	8.88	0.147	0.39	1.65	2.25	20
Нүүрсний агуулах	0-10 см	9.04	0.129	0.56	1.48	1.6	15
Хаягдлын овоолго	0-10 см	8.79	0.460	0.47	1.48	1.2	12

Ажилчдын хотхоны хөрс дунд шүлтлэг, бусад талбайн хөрс маш хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, карбонаттай, ялзмагийн агууламж бага, давсжилт бага, хөдөлгөөнт фосфорын болон калийн агууламж бага буюу үржил шим багатай. Ялзмагийн агууламж, үржил шимт бодисын агууламж бага, рН их байгаа нь тухайн бүс нутгийн хөрсөн бүрхэвчийн онцлог юм.

Хүснэгт № 27. Хөрсний механик бүрэлдэхүүн, 2024 оны 5 дугаар сар

Дээжийн нэр	Дээж авсан гүн	Механик ширхгүүд, % ширхгийн хэмжээ						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Ажилчдын хотхон	0-10 см	28.3	56.0	5.4	1.0	4.9		10.3
Засварын газар	0-10 см	22.3	29.1	18.1	1.7	21.5	7.2	30.5
ШТС	0-10 см	39.3	47.8	2.8	4.4	3.1	4.4	9.4
Уурхайн машин паркын талбай	0-10 см	30.1	52.9	7.1	1.7	6.3	10.8	9.9
Хаягдлын овоолго	0-10 см	23.1	31.0	8.9	17.3	12.4	7.3	36.9
Нүүрсний агуулах	0-10 см	35.0	45.4	8.9	1.1	7.2	2.5	10.7
Хогийн цэг	0-10 см	19.0	60.5	4.6	0.0	5.2	2.0	16.0

Ажилчдын хотхоны хөрс элсэнцэр, машин паркын талбай болон засварын газрын хөрс хөнгөн шавранцар, ШТС-ын хөрс дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй.

Хүснэгт № 28. Шимт хөрсний

Дээжний дугаар	Гүн, см	pH	Давс	ЦДЧ dS/m	Ялзмаг %	NO ₃ мг/100г	CaCO ₃ %	Шингээгдсэн сууриуд Мг-экв/100г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Шимт хөрс 1	0-10 см	8.79	0.04	0.099	0.16	0.08	0.66	5.5	4.4	0.8	12

Дээжийн нэр	Дээж авсан гүн	Механик ширхгүүд, % ширхгийн хэмжээ						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Шимт хөрс	0-10 см	37.6	49.3	3.4	0.4	7.1	2.2	9.7

Дүгнэлт: Алаг Цав уурхайн шимт хөрсний овоолгоос дээжлэлт авч шинжилгээний үр дүнг үзэхэд ялзмагийн агууламж 0.16% байгаа нь урт хугацаанд шимт хөрсийг хадгалахад хөрсний чанар алдагдах биологийн нөхөн сэргээлтэд шимт хөрсийг ашиглахад ургамал ургах шимт тэмжээл, ялзмагийн агууламж дутагдах эрсдэлтэй тул шимт хөрсний овоолгыг нэг болон олон наст ургамал тарих арга хэмжээг авах нь зүйтэй.

12.4.5. Хөрсний хүнд металлын бохирдол

Хүний үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалж ямар нэгэн химийн бодис болон биологийн элементээр хөрс бохирдож, хөрсөн дэх химийн бодис элементийн агууламж зөвшөөрөгдөх стандарт хэмжээнээс илүү болох үйл явцыг хөрс бохирдох гэнэ. Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус, нефтийн бүтээгдэхүүний асгаралт гэх мэт олон эх үүсвэрүүд багтдаг. Хөрсний бохирдол болон элэгдэл, эвдрэл нь хоорондоо салшгүй холбоотой байдаг. Бохирдсон хөрс ихэнх тохиолдолд эвдрэлд орсон байдаг.

Хүнд металлын бохирдолын судалгааг хөрсний бохирдол үүсэх эрсдэлтэй талбай болох кемп, хог хаягдлын ангилан ялгах түр цэг, засварын газрын ашигласан тосны хадгалах цэг, ШТС, Уурхайн машин паркын талбай, хаягдлын овоолго, нүүрсний агуулахын орчмоос дээж авч шинжилгээ хийгдсэн.

Хүснэгт № 29. Хөрсний хүнд металлын бохирдлын үндсэн үзүүлэлтүүд

Дээжний дугаар	Гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr	Pb	Cd	Ni	Cu	Zn
Кемп	Өнгөн хөрс (0-10 см)	ND	ND	ND	ND	ND	55.36
Хатуу хог хаягдлын цэг	Өнгөн хөрс (0-10 см)	0.49	ND	ND	7.81	0.87	51.29
Засварын газар	Өнгөн хөрс (0-10 см)	ND	ND	ND	13.50	3.37	60.21
ШТС	Өнгөн хөрс (0-10 см)	11.33	144	ND	6.89	9.89	55.29
Уурхайн машин паркын талбай	Өнгөн хөрс (0-10 см)	ND	ND	ND	2.02	0.22	51.19
Хаягдлын овоолго	Өнгөн хөрс (0-10 см)	ND	ND	ND	31.81	2.36	51.27
Нүүрсний агуулах	Өнгөн хөрс (0-10 см)	ND	ND	ND	13.78	2.89	63.29
Хүлцэх агууламж		150.0	100.0	3.0	150.0	100.0	300.0
Хортой агууламж		400.0	500.0	10.0	1000.0	500.0	600.0
Аюултай агууламж		1500.0	1200.0	20.0	1800.0	1000.0	1000.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт		MNS 5850:2019					

12.4.6. Дүгнэлт:

Алаг Цав уурхайн хөрсний хяналт шинжилгээг улирал тутам хийж байгаа бөгөөд “Инженер геофизи ХХК”-ийн хөрс судлалын лабораторийн шинжилгээний дүнгээс харахад бохирдуулагч элементүүд нь стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна.

Алаг Цав уурхай нь хөрсөнд хүнд металлын бохирдол үүсгэхээс сэргийлж ШТС болон Засварын газар, хог хаягдлын цэг, ШТМ-ын агуулахыг хөрснөөс тусгаарлаж бетонон хучилттай болгосон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлсэн байна.

12.5. УРГАМЛАН НӨМРӨГ

12.5.1. Судалгааны ерөнхий тойм

Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах “Алаг-цав”-ын нүүрсний уурхай орчмын ургамалжилтын судалгааг 2024 оны 10-р сарын 12, 13-нд хийсэн. Энэ ажлын хүрээнд нүүрсний уурхай орчмын 4 цэгт ургамлын хяналт шинжилгээний бичиглэл хийж үнэлэлт дүгнэлт өгөв.

12.5.2. Ургамалжлын ерөнхий төлөв

Судалгааны талбай болох уурхай орчмын бүс нутаг нь Ургамал-газарзүйн мужлалаар Евразийн хээрийн муж, Умард говийн цөлийн хошуунд багтах Дорнод Говийн цөлийн хээрийн тойрог, Өндөр шилийн районд хамаарна (Юнатов, 1977).

Энд тарчиг намхан ургамалтай шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), сибир хармаг (*Nitraria sibirica* Pall.)-ны довцог бүхий сайрын хялгана (*Stipa glareosa* P. Smirn.) - зүүн гарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.)-т Дорнод говийн тойрогт өргөн тархсан бүлгэмдэлүүдийн шинж төлөвийг хадгалсан.

Судалгаа хийгдсэн уурхай талбай нь далайн түшинээс дээш 950 метр-1100 метр өргөгдсөн ерөнхийдөө тэгшивтэр аараг толгодын дундах хөндий бөгөөд үржил шимт давхарга нимгэн, бор өнгөтэй жижиг чулуутай элсэнцэр хөрстэй.

Ургамалжлын хувьд тус уурхайн талбай орчимд ихэвчлэн сайрын хялгана (*Stipa glareosa* P. Smirn.), саваан булган сүүл (*Chloris virgata* Sw.), зүүн гарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), хөмөл (*Allium mongolicum* Rgl.), таана (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.) бүхий шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), сибир хармаг (*Nitraria sibirica* Pall.)-ны довцогт хээр зонхилон

тархаж байлаа. Мөн уурхайн шимт хөрсний овоолгон дээр нэг наст ургамал (ногоон хоног будаа (*Setaria viridis*), үслиг манан хамхаг (*Bassia dasyphylla*))-ын синус үүсгэсэн байлаа.

12.5.3. Судалгааны аргазүй

Хээрийн судалгааг хийхдээ тухайн бүлгэмдэлд ургамлан бүлгэмдлийн зүйлийн бүрдэлийг илрүүлж Бүлгэмдлийн нийт бүрхэц, халцгай газар, хагд болон зүйл тус бүрийн тусгагийн бүрхэцийг нүдэн баримжаагаар хувиар үнэлнэ. Ургамлан бүлгэмдлийн зүйлийн арвийг сонгон авсан талбай дахь бодгалийг нүдэн баримжаагаар тооцож Друде(1913)-н 6 баллын шатлалаар үнэлнэ. А.А. Уранов (1935) Друде-ийн хуваарийг тухайн зүйл ургамал хоорондын хамгийн бага зайтай холбон гаргасан. (Хүснэгт – 1). Ургамлын зүйлийн нэрийг онооход Грубов (1982)-ын тодорхойлох бичиг, Ургамлын зүйлийн статусыг эмийн болон ашигт ургамлын илтгүүр зүйлийг Лигаа ба бусад (2005); ховор, нэн ховор статусыг Байгалийн ургамлын тухай хууль, 1995, МУ-ын Улаан ном, 1987, 1997, 2013; 2014 -ийг ашигласан болно.

Хүснэгт № 30. Ургамлын арви, тусгагийн бүрхэц, тааралдаа хоорондын харьцаа

Друде-ийн хуваарь		100м ² дахь бодгалийн тоо	Тааралдаа (%)	Тусгагийн бүрхэц (%)
SOC (socialis) Нэлэнхүй бүрхсэн	Ургамлан бүлгэмдлийн үндсэн фон үүсгэнэ.	-	100	100
COP₃ (copiosae) Арви маш их	Их л жижиг ургамал биш бол ургамлан бүлгэмдлийн эсвэл ташингын үндсэн фон үүсгэнэ.	425	100	50-100
COP₂ Арви их	Үргэлжилсэн биш фон үүсгэнэ.	268	100	25-50
COP₁ Арвин	Фон үүсгэхгүй	100	100-75	10-25
SP (sparsae) цөөн тааралддаг	Их л том ургамал биш бол фон үүсгэхгүй	60	75-40	1-10
SOL (solitaries) ховор тааралддаг	Фон үүсгэхгүй, тод өнгө, хэмжээ зэргээрээ бусдаас ялгарч болно.	30	40	1
RR (rare) ганц нэг тааралддаг	-	2-5(10)	-	-
UN (unicum) цорын ганц	-	1	-	-

12.5.4. Судалгааны үр дүн

Алаг Цав уурхайн ургамалжилтын зүйлийн бүрдэл

Ургамалжилтын судалгаагаар нийтдээ **16 овог, 30 төрөлд** хамаарагдах **35 зүйлийн цорогт** дээд ургамал бүртгэгдэв (Хүснэгт). Судалгааны талбайд тэмдэглэгдсэн нийт ургамлын зүйлийн бүрэлдхүүнд **ховор ургамал - 3, эмийн - 2, хүнсний - 4 зүйлийн ургамал** тэмдэглэгдсэн байна.

Хүснэгт № 31. Алаг цав” нүүрсний уурхай орчмын талбай дахь ургамлын зүйлийн бүрдэл

Овог	Тоо		Зүйлийн латин нэр	Зүйлийн монгол нэр	Ургамлын нас	Амьдралын хэлбэр	Ургамлын аж ахуйн бүлэг	Ач холбогдол болон статус
	Төрөл	Зүйл						
1			Рoaceae - Үетэн					
	1	1	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	P	N	Үетэн	B
	2	2	Cleistogenes songorica (Roshev.) Ohwi.	Зүүн гарын хазаар өвс	P	N	үетэн	B
	3	3	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	A	N	Үетэн	B
	4	4	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	A	N	Үетэн	B
	5	5	Eragrostis minor Host	Бага хургалж	A	N	Үетэн	B
2	Leguminosae - Буурцагтаний овог							
	6	6	Caragana brachypoda Pojark.	Хойрог харгана	P	S	Буурцагтан	B
		7	Caragana micropylla (Pall.) Lam.	Бяцхан навчит харгана	P	S	Буурцагтан	B
		7	8	Oxytropis aciphylla Ldb.	Өргөст ортууз	P	S	Буурцагтан
3	Cyperaceae - Улалжийн овог							
	8	9	Carex duriuscula C.A.Mey.	Ширэг улалж	P	N	Улалж	B
4	Liliaceae - Сарааны овог							
	9	10	Allium polyrrhizum Turcz. ex RgL.	Таана	P	N	Алаг өвс	H, B
		11	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	P	N	Алаг өвс	гг, H, B
5	Convolvulaceae - Сэдэргэний овог							
	10	12	Convolvulus fruticosus Pall.	Сөөгөн сэдэргэнэ	P	N	Алаг өвс	B
6	Chenopodiaceae - Луулийн овог							
	11	13	Salsola collina Pall.	Толгодын бударгана	A	N	Алаг өвс	B
		14	Salsola passerina Bge.	Бор бударгана	A	N	Алаг өвс	B
		15	Salsola Paulsenii Litw.	Паульсены бударгана	A	N	Алаг өвс	B
	12	16	Corispermum mongolicum Iljin	Монгол хамхуул	A	N	Алаг өвс	B
	13	17	Bassia dasyphylla (Ficsh. et Mey.) Ktze.	Үслиг манан хамхаг	A	N	Алаг өвс	B
	14	18	Eurotia ceratiodes (L.) C. A. Mey	Орог тэсэг	P	N	Алаг өвс	B
	15	19	Anabasis brevifolia C. A. Mey.	Ахар навчит баглуур	P	N	Алаг өвс	B
7	Polygonaceae - Тарнын овог							
	16	20	Rheum nanum Sievers.	Намхан гишүүнэ	P	N	Алаг өвс	B

	17	21	<i>Atraphaxis frutescens</i> (L.) K. Koch	Сөөгөн эмгэн шилбэ	P	N	Алаг өвс	B
8	Scrophulariaceae - Иршимбийн овог							
	18	22	<i>Ajania achileoides</i> (Turcz.) Poljak.	Төлөгчдүү боролз	P	N	Алаг өвс	B
	19	23	<i>Asterothamnus molliusculus</i> Novopokr.	Зөөлөвтөр лавай	P	N	Алаг өвс	B
9	Compositae - Нийлмэл цэцэгтэний овог							
	20	24	<i>Scorzonera divaricata</i> Turcz.	Дэрэвгэр хавьсгана	P	N	Алаг өвс	гг, B
	21	25	<i>Artemisia frigida</i> Willd.	Агь	P	N	Шарилж	B
		26	<i>Artemisia xerophytica</i> Krasch.	Хуурайсаг шарилж	P	N	Шарилж	B
	22	27	<i>Tugarinovia mongolica</i> Iljin.	Монгол шар далан	P	N	Алаг өвс	B
10	Plumbaginaceae – Хорголжингийн овог							
	23	28	<i>Limonium tenellum</i> (Turcz.) Ktze.	Нарийн бэрмэг	P	N	Алаг өвс	B
11	Rutaceae - Сүлүүгийн овог							
	24	29	<i>Haplophyllum dauricum</i> (L.) G. Don	Дагуур хүж өвс	P	N	Алаг өвс	E, B
12	Tamaricaceae - Сухайн овог							
	25	30	<i>Reaumuria soongorica</i> (Pall.) Maxim.	Зүүнгарын бутаргана	P	S		B
13	Brassicaceae - Тоонолжин цэцэгтэн							
	26	31	<i>Dontostemon perennis</i> C. A. Mey.	Олон наст багдай	P	N	Алаг өвс	B
14	Rosaceae - Сарнайн овог							
	27	32	<i>Amygdalus mongolica</i> Maxim.	Монгол бүйлээс	P	N		E, H, B
15	Zygophyllaceae – Хотирын овог							
	28	33	<i>Zygophyllum xanthoxylon</i> (Bge.) Maxim.	Шар хотир	P	S		B
	29	34	<i>Nitraria sibirica</i> Pall.	Сибирь хармаг	P	S		H, B
16	Geraniaceae - шимтэглэйн овог							
	30	35	<i>Erodium tibetanum</i> Edgew.	Төвд заан таваг	P	N	Алаг өвс	B


Тэмдэглэгээ:

P-олон наст, A-нэг наст, N-өвслөг, S-сөөглөг, гг-ховор, E-эмийн, H-хүнсний, B-бэлчээрийн

2023 онд уурхай орчим хийсэн ургамлын судалгааны дүнгээр луулийн овог-6 зүйл, үетний овог- 4 зүйл, бусад овог 1-2 зүйлтэй тохиолдож байсан байна. Түүнчлэн зүйлүүдийн дотроос сөөг-6 зүйл 25%, нэг наст ургамал 4 зүйл 16,6% байгаа бөгөөд 14 зүйл 58,3% нь олон наст ургамал ургаж байгааг тогтоосон.

Харин 2024 онд нүүрсний уурхайн ашиглалтын талбай орчмын ургамлын овгуудын дотроос луулийн овог-7 зүйл, үетний овог- 5 зүйл, нийлмэл цэцэгтэний овог – 4 зүйл бусад овог 1-2 зүйлтэй тохиолдож байна (График-1).

Насны байдлаар нь авч үзвэл нэг наст – 8 зүйл 22,9% байгаа бөгөөд олон наст – 27 зүйл 77,1 эзэлж ургамал байна.



График№ 7. Уурхайн орчмын ургамлын овгуудын эзлэх хэмжээ (А- 2023 он В- 2024 он)

12.5.5. Уурхайн талбай орчмын ургамлын бичиглэл.

Бичиглэл-1: Байршил: $N 44^{\circ} 07' 452''$ $h=996 m$
 $W 108^{\circ} 17' 121''$

Уурхайн зүүн урд хэсэгт шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана таанат цөлөрхөг хээрийн бүлгэмдэлийн тусгагын бүрхэц нь 35% - 45%, бөгөөд $1m^2$ талбайд 5 зүйл ургамал тохиолдоно. Бяцхан навчит харгана - 3%, Зүүн гарын хазаар өвс - 5%, хөмөл -10%, улалж-2%, харин нэг настнаас саваан булган сүүл -15% -ийн бүрхэцтэй байсан (хүснэгт-3).

Хүснэгт № 32. Бичиглэл №1 (1 м²-ийн ургамал)

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг	Арви	Бүрхэц %
1	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	нэг наст	Өвслөг	үетэн	Cop	15
2	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	Олон наст	Өвслөг	Алаг өвс	Cop	10
3	Cleistogenes songorica (Roshev.) Ohwi.	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	үетэн	Sp	5
4	Carex duriuscula C.A.Mey.	Ширэг улалж	Олон наст	Өвслөг	Улалж	Sol	2
5	Caragana micropylla (Pall.) Lam.	Бяцхан навчит харгана	Олон наст	Сөөглөг	Буурцагтан	Sol	3

Хүснэгт № 33. Бичиглэл №1 орчмын ургамлын зүйлийн бүрдэл

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг
1	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	Нэг наст	Өвслөг	Үетэн
2	Carex duriuscula C.A.Mey.	Ширэг улалж	Олон наст	Өвслөг	Улалж
3	Caragana micropylla (Pall.) Lam.	Бяцхан навчит харгана	Олон наст	Сөөглөг	Буурцагтан
4	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	Олон наст	Өвслөг	Алаг өвс
5	Cleistogenes songorica (Roshev.)	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	Үетэн
6	Tugarinovia mongolica Iljin.	Монгол шар далан	Олон наст	Өвслөг	Алаг өвс
7	Convolvulus fruticosus Pall.	Сөөгөн сэдэргэнэ	Олон наст	Өвслөг	Алаг өвс
8	Caragana brachypoda Pojark.	Хойрог харгана	Олон наст	Сөөглөг	Буурцагтан
9	Reaumuria soongorica (Pall.)	Зүүнгарын бутаргана	Олон наст	Сөөглөг	
10	Eurotia ceratioides (L.) C. A. Mey	Орог тэсэг	Олон наст	Өвслөг	Алаг өвс
11	Salsola passerina Bge.	Бор бударгана	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
12	Eragrostis minor Host	Бага хургалж	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
13	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн
14	Bassia dasyphylla (Ficsh. et Mey.)	Үслиг манан хамхаг	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
15	Salsola Paulsenii Litw.	Паульсены бударгана	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
16	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	Нэг наст	Өвслөг	Алаг өвс

17	Scorzonera divaricata Turcz.	Дэрэвгэр хавьсгана	Олон наст	Өвслөг	Алаг өвс
18	Zygophyllum xanthoxylon (Bge.)	Шар хотир	Олон наст	Сөөглөг	
19	Nitraria sibirica Pall.	Сибирь хармаг	Олон наст	Сөөглөг	
20	Allium polyrrhizum Turcz.	Таана	Олон наст	Өвслөг	Алаг өвс

Ургамлын бичиглэл №1 орчмын 100 м² талбайд нийт 20 зүйл ургамал бүртгэсэн (хүснэгт-4)-ээс олон наст-14, нэг наст-6 зүйл ургамал байна.



Зураг№ 55. Ургамлын бичиглэл №1 шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана - таанат цөлөрхөг хээрийн бүлгэмдэл

Бичиглэл-2:

Байршил: N 44° 06' 617''
W 108° 21' 227''

h=1012 m

Уурхайн урд хэсэгт 1 км орчимд жижиг аарагын өмнөд энгэрт шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст цөлөрхөг хээрийн бүлгэмдэлийн тусгагын бүрхэц нь 30% бөгөөд 1м² талбайд 7 зүйл ургамал тохиолдоно. Сайрын хялгана - 15%, Зүүн гарын хазаар өвс - 10%, хөмөл -5%, дагуур хүж өвс -3%, харин нэг наст гурван зүйл ургамал -5% -ийн бүрхэцтэй байсан (хүснэгт-5).

Хүснэгт № 34. Бичиглэл №2 (1 м²-ийн ургамал)

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг	Арв н	Бүрхэц %
1	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн	Cop	15
2	Cleistogenes songorica (Roshev.) Ohwi.	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	үетэн	Cop	10
3	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	Олон наст	Өвслөг	Алаг өвс	Sp	5
4	Haplophyllum dauricum (L.) G. Don	Дагуур хүж өвс	Олон наст	Өвслөг	Үетэн	Sp	3
5	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	Нэг наст	Өвслөг	Үетэн	Sol	2
6	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Sol	1
7	Eragrostis minor Host	Бага хургалж	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Sol	2

Хүснэгт № 35. Бичиглэл №2 орчмын ургамлын зүйлийн бүрдэл

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг
1	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн
2	Haplophyllum dauricum (L.) G.	Дагуур хүж өвс	Олон наст	Өвслөг	Алаг өвс
3	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	Нэг наст	Өвслөг	үетэн
4	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
5	Eragrostis minor Host	Бага хургалж	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
6	Cleistogenes songorica (Roshev.)	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	үетэн
7	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	Олон наст	Өвслөг	Алаг өвс

8	Zygophyllum xanthoxylon Maxim.	Шар хотир	Олон наст	Сөөглөг	
9	Nitraria sibirica Pall.	Сибирь хармаг	Олон наст	Сөөглөг	
10	Allium polyrrhizum Turcz. ex RgL.	Таана	Олон наст	Өвслөг	Алаг өвс
11	Atraphaxis frutescens (L.) K. Koch	Сөөгөн эмгэн шилбэ	Олон наст	Өвслөг	Алаг өвс
12	Erodium tibetanum Edgew.	Төвд заан таваг	Олон наст	Өвслөг	Алаг өвс
13	Rheum nanum Sievers.	Намхан гишүүнэ	Олон наст	Өвслөг	Алаг өвс
14	Amygdalus mongolica Maxim.	Монгол бүйлээс	Олон наст	Сөөглөг	
15	Limonium tenellum (Turcz.) Ktze.	Нарийн бэрмэг	Олон наст	Өвслөг	Алаг өвс
16	Astrothamnus molliusculus Novopokr.	Зөөлөвтөр лавай	Олон наст	Өвслөг	Алаг өвс
17	Tugarinovia mongolica Iljin.	Монгол шар далан	Олон наст	Өвслөг	Алаг өвс
18	Caragana brachypoda Pojark.	Хойрог харгана	Олон наст	Сөөглөг	Буурцагтан
19	Salsola collina Pall.	Толгодын бударгана	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
20	Ajania achileoides (Turcz.) Poljak.	Төлөгчдүү боролз	Олон наст	Өвслөг	Алаг өвс
21	Artemisia frigida Willd.	Агь	Олон наст	Өвслөг	Шарилж
22	Reaumuria soongorica (Pall.) Maxim.	Зүүнгарын бутаргана	Олон наст	Сөөглөг	

Ургамлын бичиглэл №2 орчмын 100 м² талбайд нийт 22 зүйл ургамал бүртгэсэн (хүснэгт-6)-ээс олон наст-18, нэг наст-4 зүйл ургамал байна.



Зураг № 56. Ургамлын бичиглэл №2 шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст хээрийн бүлгэмдэл

Бичиглэл-3: Байриил: $N 44^{\circ} 06' 012''$ $h=985 m$
 $W 108^{\circ} 15' 352''$

Уурхайн кемп рүү орох хаалга орчимд шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст цөлөрхөг хээрийн бүлгэмдэлийн тусгагын бүрхэц нь 45% -50% бөгөөд 1м² талбайд 5 зүйл ургамал тохиолдоно. Зүүн гарын хазаар өвс - 10%, Сайрын хялгана - 3%, хөмөл -5%, харин нэг наст ургамал -5% -ийн бүрхэцтэй байсан (хүснэгт-7).

Хүснэгт № 36. Бичиглэл №3 (1 м²-ийн ургамал)

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг	Арв и	Бүрхэц %
1	Cleistogenes songorica (Roshev.) Ohwi.	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	үетэн	Сор	10
2	Allium mongolicum Rgl.	Монгол сонгино, хөмөл	Олон наст	Өвслөг	Алаг өвс	Sp	5
3	Eragrostis minor Host	Бага хургалж	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Sp	5
4	Artemisia xerophytica Krasch.	Хуурайсаг шарилж	Олон наст	Өвслөг	Шарилж	Sp	4
5	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн	Sp	3

Ургамлын бичиглэл №3 орчмын 100 м² талбайд нийт 13 зүйл ургамал бүртгэсэн (хүснэгт-8)-ээс олон наст-9, нэг наст-4 зүйл ургамал байна.

Хүснэгт № 37. Бичиглэл №3 орчмын ургамлын зүйлийн бүрдэл

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг
1	Zygophyllum xanthoxylon Maxim.	Шар хотир	Олон наст	Сөөглөг	
2	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн
3	Cleistogenes songorica (Roshev.)	Зүүн гарын хазаар өвс	Олон наст	Өвслөг	үетэн
4	Bassia dasphylla (Ficsh. et Mey.)	Үслиг манан хамхаг	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
5	Oxytropis aciphylla Ldb.	Өргөст ортууз	Олон наст	Сөөглөг	Буурцагтан
6	Dontostemon perennis C. A. Mey.	Олон наст багдай	Олон наст	Өвслөг	Алаг өвс
7	Salsola collina Pall.	Толгодын бударгана	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
8	Convolvulus fruticosus Pall.	Сөөгөн сэдэргэнэ	Олон наст	Өвслөг	Алаг өвс
9	Chloris virgata Sw.	Саваан булган сүүл	нэг наст	Өвслөг	үетэн
10	Artemisia xerophytica Krasch.	Хуурайсаг шарилж	Олон наст	Өвслөг	Шарилж
11	Anabasis brevifolia C. A. Mey.	Ахар навчит баглуур	Олон наст	Өвслөг	Алаг өвс
12	Reaumuria songorica (Pall.)	Зүүнгарын бутаргана	Олон наст	Сөөглөг	
13	Corispermum mongolicum Iljin	Монгол хамхуул	Нэг наст	Өвслөг	Алаг өвс



. Зураг № 57. Ургамлын бичиглэл №3 шар хотир, сибир хармаг бүхий говийн хялгана – зүүн гарын хазаар өвст хээрийн бүлгэмдэл

Бичиглэл-4:

Уурхайн кемп хашаан дотор ногоон хоног будаа, үслиг манан хамхагын синуз үүсгэсэн, тусгагын бүрхэц нь 50% - 80% бөгөөд 1м² талбайд 3 зүйл ургамал тохиолдоно. Ногоон хоног будаа - 40%, үслиг манан хамхаг - 20%, дэрэвгэр хавьсгана -5%, -ийн бүрхэцтэй байсан (хүснэгт-9).

Хүснэгт № 38. Бичиглэл №4 (1 м²-ийн ургамал)

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг	Арв и	Бүрхэц %
1	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Сор	40
2	Bassia dasyphylla (Ficsh. et Mey.)	Үслиг манан хамхаг	Нэг наст	Өвслөг	Алаг өвс	Сор	20
3	Scorzonera divaricata Turcz.	Дэрэвгэр хавьсгана	Олон наст	Өвслөг	Алаг өвс	Sp	5

Ургамлын бичиглэл №4 орчмын талбайд нийт 7 зүйл ургамал бүртгэсэн (хүснэгт-10)-ээс олон наст-3, нэг наст-4 зүйл ургамал байна.

Хүснэгт № 39. Бичиглэл №4 орчмын ургамлын зүйлийн бүрдэл

№	Латин нэр	Монгол нэр	Нас	Амьдралын хэлбэр	Аж ахуйн бүлэг
1	Setaria viridis (L.) P. B.	Ногоон хоног будаа	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
2	Bassia dasyphylla (Ficsh. et Mey.)	Үслиг манан хамхаг	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
3	Scorzonera divaricata Turcz.	Дэрэвгэр хавьсгана	Олон наст	Өвслөг	Алаг өвс
4	Eragrostis minor Host	Бага хургалж	Нэг наст	Өвслөг	Алаг өвс
5	Stipa glareosa P. Smirn.	Сайрын хялгана	Олон наст	Өвслөг	Үетэн
6	Dontostemon perennis C. A. Mey.	Олон наст багдай	Олон наст	Өвслөг	Алаг өвс
7	Corispermum mongolicum Iljin	Монгол хамхуул	Нэг наст	Өвслөг	Алаг өвс



Зураг № 58. Ургамлын бичиглэл №4 ногоон хоног будаа, үслиг манан хамхагын синүз үүсгэсэн талбай

12.5.6. Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

Уурхайн олборлолт болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас ургамал бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бэлчээр хамгаалах, сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Уурхай орчмын бүсэд нутгийн унаган ургамал, болон тэр орчимд ургаж буй бут сөөгийг ашиглах, ургах чадвар сайтай, нөхөн сэргэлтэнд ашиглах боломжтой нутгийн ургамлын үрийн бэлтгэх, тарих туршилт судалгаа хийх, зэрэг ажлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүйцэтгэх.
2. Нүүрс тээвэрлэх болон уурхайн үйл ажиллагаатай холбоотой авто тээврийн хөдөлгөөн нь ургамал бүлгэмдлийг талхлагдалд оруулахгүй байх, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухайлбал: тээвэрийн хэрэгсэлийг тогтсон нэг замаар явуулж байх, тухайн замын дагуу анхааруулга бүхий түр тэмдэглэгээг бий болгох, авто машинаас гарч буй тоосжилтыг дарахын тулд усаар чийглэж өгөх, тоосжилтыг тусгай багажийн тусламжтайгаар хянаж байх, түүн дээр тулгуулан зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
3. Шимт хөрсний овоолгод эхний ээлжинд нэг наст ургамлуудыг зарим олон наст ургамалтай холимог байдлаар тарих. Тухайлбал: Сайрын хялгана (*Stipa glareosa*) 30%, Зүүн гарын хазаар өвс (*Cleistogenes songorica*) 20%, ногоон хоног будаа (*Setaria viridis*) 15%, Үслиг манан хамхаг (*Bassia dasyphylla*) 10%, бага хургалж (*Eragrostis minor*) 10%, дэрэвгэр хавьсгана (*Scorzonera divaricata*) 10% байна. Энэ нь тухайн хөрсний алдагдсан бүтцийг сэргээх, хөрс хийсэх, хөрсний чийг хадгалах ач холбогдолтой.

Зураг № 59. Ургамлын зурагт альбом



Зураг-1 Толбот бэрээмэг. (*Arnebia guttata* Bge.)



Зураг-2. Ацан ажигана. (*Stellaria dichotoma* L.)



Зураг 3. Намхан гишүүнэ. (*Rheum nanum* Sievers.)



Зураг 4. Дэрэвгэр хавьсгана (*Scorzonera divaricata* Turcz.)

Зураг 5. Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.)

Зураг 6. Монгол сонгино, хөмөл (*Allium*



mongolicum Rgl.)




12.6.АЛАГ ЦАВ ТӨСЛИЙН 2024 ОНЫ АМЬТНЫ АЙМГИЙН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

12.6.1. Судлагдсан байдал

Дорноговь аймгийн Мандах сумын нутаг нь Төв Азийн их говь цөлийн бүсэд цөлийн хээр, цөлжүү хээр болон элсэрхэг гадаргын гурван үндсэн бүрэлдэхүүнд хуваарилагдсан байдаг(Цэгмид, 1969). Иймд говь цөлийн экосистемд байнга тархан байршдаг хоёр нутагтан, мөлхөгчид, шувууд, хөхтөн амьтад тархан байршдаг онцлогтой. Амьтны газар зүйн мужлалаар (Банников 1954) Хойд говийн тойрогт хамаарах бөгөөд жижиг толгодын сайр садаргаар ихээхэн хэрчигдсэн харгана, буйлст, хайрга чулуурхаг зарим хэсэгт хужир мараа бүхий дэрс, түнгэт хотгор бүхий янз бүрийн биотоптой (Амгалан 2023).

Бүс нутгийн тархацыг зүйл тус бүрийн тархацыг Монгол орны тодорхой бүс нутгаар ялган Монгол улсын физик газар зүйн зургийг үндэслэн Цэгмид (1969), Grubov (1982), Рачковская (1993), Банников (1954) нарын ургамал, хөхтөн амьтны газар зүйн мужлалын зургаар сэлбэн баяжуулж, Н. Батсайхан цэгцлэн (Зураг 1) 16 бүсэд хуваасан зураг хөхтөн амьтны тархалтыг ургамлын газарзүйтэй холбон урьдынхаас арай тод томруун харуулжээ.



Зураг № 60. Монгол орны хөхтөн амьтдын тархацын зураг

Монгол орны газарзүйн мужууд (Цэгмид, 1969; Грубов, 1982).

1 = Хөвсгөлийн уулс, 2 = Хэнтий нуруу, 3 = Хангайн нуруу, 4 = Монгол Дагуурын хээр, 5 = Их хянганы уулс, 6 = Монгол Алтайн нуруу, 7 = Төв халхын хээр, 8 = Дорнод Монгол, 9 = Их нууруудын хотгор, 10 = Олон нуурын хөндий, 11 = Умард говь, **12 = Дорнод говь**, 13 = Говь Алтай нуруу, 14 = Зүүнгарын говь цөл, 15 = Алтайн өвөр говь цөл, 16 = Алашань говь цөл.

Бид судалгаандаа Монгол орны газар зүйн Дорнод говь муж, Хойд говийн тойрогт хамрагдах хөхтөн амьтдыг өөрсдийн болон өмнөх судлаачдын хийсэн судалгаа, ном бүтээлээс магадлан авч анги, баг, төрөл, зүйлээр ялган авч үзлээ. Тохиолдож болох амьтдын хамгааллыг Монгол улсын Амьтны тухай хууль, Монгол улсын улаан ном, Улаан данс болон Олон улсын байгаль хамгаалах байгууллагуудын баримт бичигт хэрхэн үнэлэгдсэнийг тодрууллаа.

12.6.2. Судалгааны ажил

12.6.2.1. Судалгаа явуулсан маршрут

Бидний судалгаа ховор ховордож буй зүйлийг хамгаалах, тухайн популяцийн амьдарч буй нутагт тооллого явуулж экологийн тандалт судалгаа хийх замаар популяцийн төлөв байдалд өгсөн үнэлгээн дээр суурилагддаг. Тиймээс зэрлэг амьтдын мониторинг судалгааг хийхдээ «Зурвас замлалын арга»-аар маршрутын дагуу явж тааралдсан амьтад болох аргаль хонь, хулан адуу, хар сүүлтий зэргийг ажиглан, байршил тогтоож, тоо толгойг бүртгэсэн. Газрын байр зүйн зургаас ажиглан явж судласан зурвасын талбай уурхайгаас 10 километрийн радиуст хамарсан болно.

Манай судалгааны баг дараах маршрутын дагуу судалгаандаа явсан. Уурхайгаас урагшаа 5 км, баруун урагшаа 10км, баруун 10 км, баруун хойшоо 8км, хойшоо 13 км нийт ойролцоогоор 180 км² талбайд судалгаагаа хийсэн(Хүснэгт 1).


Хүснэгт № 40. Судалгааны байршилын хүснэгт

№	Байршлын нэр	Тохиолдсон амьтдын зүйлийн нэр	Өргөрөг	Уртраг	Чиглэл /уурхайгаас/	Уурхай хүртэл зай /км/	Амьтны тоо
1	Хөв цөөрөм Уст цэг №1	Амьтны мөр	44°09'085"	108°14'233"	баруун	1.44	
2		Хулан адуу	44°08'555"	108°14'130"	баруун	1.4	22
3		Шар үнэг	44°08'556"	108°14'131"	баруун	2.4	1
4	Уст цэг №2	Амьтны мөр	44°05'157"	108°12'570"	баруун урд	7.08	
5		Аргаль хонь	44°04'264"	108°12'432"	баруун урд	7.88	10
6		Хулан адуу	44°05'183"	108°12'53.2"	баруун урд	7.04	4
7		Хар сүүлтий	44°05'192"	108°10'492"	Баруун урд	8.48	7
8		Хулан жороо /өвөлжөө/	44°05'513"	108°11'116"	баруун урд	7.52	1
9	Баруун хөндий Зуслан /Ухна/	Хар сүүлтий	44°10'137"	108°10'014"	баруун хойд	7.4	3
10	Гар худаг /Халзан-Ухна/	Хулан адуу	44°11'021"	108°10'491"	баруун хойд	7.24	1
11	Арваннаймын Богд уул	Аргаль хонь	44°14'369"	108°13'096"	хойд	11.58	1
12		Аргаль хонь	44°15'226"	108°12'548"	Богд уулын зүүн хойд	13.02	7
13		Хар сүүлтий	44°14'054"	108°13'343"	хойд	10.24	5
14	Уурхайгаас урд талд 3 км-г	Цоохор хонин гүрвэл	44°07'433"	108°17'127"	урд	3.61	2

Бидний судалгаа хийсэн хугацаа 10-р сарын дундуур байсантай холбоотой шавьж, хоёр нутагтан, мөлхөгчид, зарим хөхтний идэвхи буурсан, ичээндээ орсон, нүүдлийн шувууд буцсан, буцаж байгаа онцлог үе байлаа. Иймээс бидний сонгон авсан уурхайн орчны хяналт шинжилгээний талбайд (уурхайн эргэн тойронд 10-15 км) амьтад биеэр болон нүх, ул мөр тохиолдсон.

“Алаг цав” нүүрсний ил уурхай нь Мандах сумын нутагт орших Түмэн айлын чулуун нүүрсний ордын баруун урд байрладаг учир зүүн талаараа бусад нүүрсний уурхайнуудтай хил залгаа байдаг тул энэ хэсэгтэй зэрлэг амьтан байршин нутаглах боломжгүй байна.

Орчны хяналт шинжилгээ хийж байгаа хугацаанаас гадна энэ нутагт сүүлийн 1 жил хур тунадас их байсантай холбоотой байгалийн хүчин зүйлээс хамааралтай ус даган амьдрагч уулын туруутан хөхтөн, суурин амьдардаг шувуудын тоо толгой тархац, байршил нутгаар тархан нүүж тэлэхэд ихээхэн нөлөөлсөн байна.



Зураг № 61. Судалгааны явцад ажиглагдсан амьтадын байршил

Энэ уурхайн байршил нутгийн нэг онцлог нь нутгийн иргэдийн тахин шүтэж байдаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Арван наймын Богд уул юм. Хайрханы баруун, зүүн салбар уулсаар булаг шанд элбэгтэй, намар орой сөл тасардаг тул аргаль хонь, янгир ямаа, хулан адуу, хар сүүлт зэрэг ховор амьтад байршин нутаглаж байдаг онцлогтой. Уурхайгаас хойно 12 км-т ховор уулын туруутан байршдаг гол нутаг.



Зураг№ 62. Арван наймгийн Богд уул (Орон нутгийн тусгай хамгаалалттай газар)



Зураг№ 63. Уурхайн баруун урд талын хөндий

12.6.3. Хоёр нутагтан, мөлхөгчид

Энэ нутагт өмнөх судлаачдын бүтээлийг шүүж үзэхэд 1 зүйл хоёр нутагтан, 6 зүйл мөлхөгчид байрших бөгөөд зүйл тус бүр өөр өөрийн амьдрах бичил орчинд тохиолдох онцлогтой. Эдгээр зүйлүүд Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан дансанд өргөн тархацтай анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн байдаг. Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) улаан дансанд эдгээр зүйлүүд үнэлгээ хийгдээгүй байгаа нь дээрхи амьтдын Монгол орон дахь судалгааны мэдээлэл хомс, тодорхой судалгаа хийгдээгүйн улмаас хамгааллын статус олон улсын хэмжээнд тодорхойгүй гэсэн үг юм.

Бүх хоёр нутагтан, мөлхөгчид нь тодорхой биотопд амьдрах онцлогтой тул нүүдэл шилжилт хөдөлгөөн хийх нь маш ховор. Иймээс уул уурхайн хайгуул, олборлолтийн үйл ажиллагаа тухайн орчны амьтдыг хүйс бүлээр нь устгах, амьдрах орчны доройтол, хомсдолд хүргэж байгаа бөгөөд хэрэв энэ үйл ажиллагаа цаашид улам өргөжвөл ховордуулах гол шалтгаан болно.

Зураг №6. Цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*) N44⁰12869; E108⁰286855



Тухайн бүс нутагт тархан байрших зүйлүүд өргөн тархацтай анхааралд өртөхөөргүй зүйлүүд учир нөлөөлөл харьцангуй бага байна. Судалгааны хугацаанд хоёр нутагтан, мөлхөгчдийн идэвхи буурсан байсан тул биетээр Цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*) 2 бодгальтай таарсан.

Хүснэгт №3. Цоохор хонин гүрвэл - *Phrynocephalus versicolor* (Frank, Ramus, 1996).

Үзүүлэлт	Тайлбар
Бүс нутгийн тархац 	Энэ зүйл нь <i>Phrynocephalus</i> төрлөөс Төв Азийн цөлд хамгийн түгээмэл тохиолддог. Говь цөл, цөлөрхөг хээр, хээрийн элдэв хэв шинжийн амьдрах орчинд түгээмэл тохиолдоно. Монголын говь, цөлд амьдардаг хамгийн өргөн тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий дөрвөн зүйл гүрвэлийн (<i>P. versicolor</i> ; <i>A. ripiens</i> ; <i>E. przewalskii</i> ; <i>E. multiocellata</i>) нэг юм. Дорнод говь, Умард говь, Алашаа говь, Монгол Алтайн нурууны өмнөд хэсэг, Алтайн өвөр ба Зүүнгарын говь, Говь Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Дорнод Монголын зүүн өмнөд хэсэг, Хангайн нурууны өмнөд хэсэг зэрэг нутгуудаар тархсан. Монгол оронд далайн түвшинээс дээш 600-2000 метрт тохиолдоно. Энэ зүйлийн Монголд тархан амьдрах нутаг 647, 991 км ² гэж үнэлэгдсэн.
Статус	Элбэг
Олон улсын үнэлгээ	Үнэлгээ хийгдээгүй
Бүс нутгийн үнэлгээ	Анхааралд өртөхөөргүй
Үнэлгээний үндэслэл	Тархац нутаг уудам, тоо толгой элбэг, нягтшил нь өндөр зүйл (Terbish нар, 2006). Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.
Хамгаалсан байдал	Цоохор хонин гүрвэлийн тархац нутгийн 18 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан (Terbish нар, 2006; UNEPWCMC, 2006).
Ховордлын шалтгаан	Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйлдвэрлэлийн үед хөрс хуулах, газар тариалангийн зориулалтаар хагалан боловсруулах явцад амьдрах орчин эвдэрч цоохор хонин гүрвэлийн тоо толгойд сөрөг нөлөөлнө. Бас малын хөлд гишгэгдэх, машинд дайруулах эрсдэл бий.

Эх сурвалж	Х.Тэрбиш., Х.Мөнхбаяр., Е.Л.Clark., Ж.Мөнхбат., Е.М.Monks., М.Мөнхбаатар., J.E.M.Baillie., Н.Батсайхан., Л.Я.Боркин., Р.Самъяа., Д.В.Семенов. (Эмхэтгэгчид, редакторууд) (2006). Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
------------	---

12.6.4. Шувууд

Судалгаа болон өмнөх судлаачдын тэмдэглэснээр энэ нутагт 8 багт хамаарах 38 зүйлийн шувууд бүртгэгдсэн байдаг байна.

